



# Хавсралт II

Санхүүгийн мөрдөн шалгах  
ажиллагаа болон мөнгөн  
хөрөнгийн эх үүсвэр ба  
зарцуулалтын дүн шинжилгээ  
ашиглан үндэслэлгүй  
хөрөнгөжилтийг нотлох нь

МӨРДӨГЧ, ПРОКУРОРУУДАД ЗОРИУЛСАН  
АРГА ЗҮЙН ЗААВАРЧИЛГАА

---

Үндэслэлгүй хөрөнгөжилт:

Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж  
боловсруулагчдад зориулсан гарын авлагын 2 дугаар хавсралт



# Хавсралт II

Санхүүгийн мөрдөн шалгах  
ажиллагаа болон мөнгөн  
хөрөнгийн эх үүсвэр ба  
зарцуулалтын дүн шинжилгээ  
ашиглан үндэслэлгүй  
хөрөнгөжилтийг нотлох нь

МӨРДӨГЧ, ПРОКУРОРУУДАД ЗОРИУЛСАН  
АРГА ЗҮЙН ЗААВАРЧИЛГАА

Үндэслэлгүй хөрөнгөжилт:

Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж  
боловсруулагчдад зориулсан гарын авлагын 2 дугаар хавсралт



**Proving illicit enrichment using financial investigation and Source and Application of Funds analysis: Technical Guidance for Investigators and Prosecutors (Annex II for *Illicit Enrichment: A Guide to Laws Targeting Unexplained Wealth*)**

By Basel Institute on Governance

**Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа болон мөнгөн хөрөнгийн эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ ашиглан үндэслэлгүй хөрөнгөжилтийг нотлох нь: Мөрдөгч, прокуроруудад зориулсан арга зүйн зааварчилгаа (*Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлагын 2-р хавсралт*)**

Базелийн Засаглалын Хүрээлэн

Редактор: А.Амармэнд

Орчуулсан: н.Энхчимэг

Эх бэлтгэсэн: Б.Тамир

Орчуулгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь төсөл”-өөс хийж гүйцэтгэв. Гарын авлагын орчуулга, агуулгатай холбоотой эргэлзээтэй зүйл гарвал Базелийн засаглалын хүрээлэнгийн цахим хаяг дахь англи эхийг харна уу.

Copyright © 2021 Basel Institute on Governance ISBN: 978-3-9525409-4-7 (PDF)

This work is licensed under a Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivatives 4.0 International License.

Please use the following citation: Dornbierer, A., 2021. *Illicit Enrichment: A Guide to Laws Targeting Unexplained Wealth. Annex II: Technical guidance for investigators and prosecutors*. Basel: Basel Institute on Governance. Available at: [illicitenrichment.baselgovernance.org](https://illicitenrichment.baselgovernance.org)

This work was funded by the core donor group of the International Centre for Asset Recovery in 2020–2021: the Government of Jersey, Principality of Liechtenstein, Norwegian Agency for Development Cooperation (Norad), Swiss Agency for Development and Cooperation (SDC) and UK Foreign, Commonwealth & Development Office (FCDO).

of the information system, the user's perception of the system's ease of use, and the user's intention to use the system.

The purpose of this study is to investigate the relationship between the user's perception of the system's ease of use and the user's intention to use the system.

The study is organized as follows. Section 2 describes the research methodology. Section 3 presents the results of the study. Section 4 discusses the implications of the study. Section 5 concludes the study.

2. RESEARCH METHODOLOGY

The study was conducted using a survey method. The survey was distributed to a sample of users who were using the information system.

The survey consisted of a series of questions that measured the user's perception of the system's ease of use and the user's intention to use the system.

The survey was distributed to a sample of 100 users who were using the information system. The sample was selected using a random sampling method.

The survey was distributed to the users via email. The survey was completed by 80 users.

The survey results are presented in Section 3. The results show a positive relationship between the user's perception of the system's ease of use and the user's intention to use the system.

The results also show that the user's perception of the system's ease of use is a significant predictor of the user's intention to use the system.

The study has several limitations. First, the study was conducted using a survey method, which may not capture all of the factors that influence the user's intention to use the system.

Second, the study was conducted with a sample of users who were using the information system, which may not be representative of all users.

Third, the study did not measure the user's actual usage of the system, which may be a better indicator of the user's intention to use the system.

Despite these limitations, the study provides valuable insights into the relationship between the user's perception of the system's ease of use and the user's intention to use the system.

The study has several implications. First, the study suggests that improving the user's perception of the system's ease of use can lead to an increase in the user's intention to use the system.

Second, the study suggests that the user's perception of the system's ease of use is a key factor in determining the user's intention to use the system.

Third, the study suggests that the user's perception of the system's ease of use is a significant predictor of the user's intention to use the system.

The study has several practical implications. First, the study suggests that system designers should focus on improving the user's perception of the system's ease of use.

Second, the study suggests that system designers should focus on making the system more user-friendly.

Third, the study suggests that system designers should focus on providing clear and concise instructions for using the system.

The study has several theoretical implications. First, the study supports the theory of the user's perception of the system's ease of use.

Second, the study supports the theory of the user's intention to use the system.

Third, the study supports the theory of the relationship between the user's perception of the system's ease of use and the user's intention to use the system.

The study has several future research directions. First, future research should investigate the relationship between the user's perception of the system's ease of use and the user's actual usage of the system.

Second, future research should investigate the relationship between the user's perception of the system's ease of use and the user's satisfaction with the system.

Third, future research should investigate the relationship between the user's perception of the system's ease of use and the user's loyalty to the system.

The study has several conclusions. First, the study shows a positive relationship between the user's perception of the system's ease of use and the user's intention to use the system.

Second, the study shows that the user's perception of the system's ease of use is a significant predictor of the user's intention to use the system.

Third, the study shows that the user's perception of the system's ease of use is a key factor in determining the user's intention to use the system.

The study has several implications for practice. First, the study suggests that system designers should focus on improving the user's perception of the system's ease of use.

Second, the study suggests that system designers should focus on making the system more user-friendly.

Third, the study suggests that system designers should focus on providing clear and concise instructions for using the system.

The study has several implications for theory. First, the study supports the theory of the user's perception of the system's ease of use.

## Энэ хавсралтын зорилго:

Энэ хавсралт нь Базелийн Засаглалын хүрээлэнгээс 2021 оны 5 дугаар сард хэвлүүлсэн *Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага* номын хавсралт болно. Энэ хавсралтаар тухайн этгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн болохыг тогтоох санхүүгийн мэдээлэл, нотлох баримтыг хэрхэн цуглуулж, дүн шинжилгээ хийх тухай зааварчилгааг мөрдөгч, прокуроруудад өгч байгаа болно. Мөн нотлох баримтын дүн шинжилгээний Эх үүсвэр ба зарцуулалтын аргачлалд суурилж, тухайн хүн өөрийн хууль ёсоор олсон орлогоор тайлбарлах боломжгүй мөнгөн хөрөнгийг (fund) олж авсан ба/ эсхүл ашигласан гэдгийг мөрдөгч, прокурорууд тодорхой бөгөөд үнэн бодитоор нь нотлоход дэмжлэг үзүүлэхийн тулд энэхүү аргыг хэрхэн ашиглаж болохыг энэ хавсралтаар тайлбарлав. Түүнчлэн энэхүү арга зүйн зааварчилгаагаар үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад шаардагдах санхүүгийн нотлох баримтын нийтлэг төрөл зүйлийн тоймыг танилцуулсан болно.

# Гарчиг

<b>1</b>	<b>Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний талаарх танилцуулга</b>	<b>10</b>
1.1	“Мөнгөн хөрөнгийн эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ” гэж юу вэ?	11
1.2	Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг авч үзсэн/хэрэглэсэн шүүхийн практик	16
1.3	Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд яагаад хэрэгтэй байдаг вэ?	17
1.4	Үндэслэлгүйгээр хөрөнгөжих бүх хэрэг дээр эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ тохиромжтой байдаг уу?	18
<b>2</b>	<b>Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээнд ашиглах мэдээлэл цуглуулах зорилгоор санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь</b>	<b>19</b>
2.1	“Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр”-ийн нийтлэг жишээ	22
2.2	“Зарцуулалт”-ын нийтлэг жишээ	24
2.3	Эх үүсвэр ба зарцуулалтын тусгай дэд зүйл: Анхаарвал зохих хугацаанаас өмнө болон уг хугацаанд “хадгалсан” эсхүл “хуримтлуулсан” мөнгөн хөрөнгө	26
2.4	Эх үүсвэр ба зарцуулалтын тусгай дэд зүйл: тодорхойгүй эх үүсвэрээс орж ирсэн бэлэн мөнгө, тодорхой бус чиглэл рүү гарсан бэлэн мөнгө	28
2.5	Тухайн этгээдийн орлого, зарцуулалтыг илтгэх санхүүгийн нотлох баримтын нийтлэг эх сурвалжууд	30
2.5.1	Хөрөнгө орлогын мэдүүлэг (Asset declarations)	30
2.5.2	Татварын буцаалтын тайлан (Tax return forms)	31
2.5.3	Ажилласан байдал	31
2.5.4	Банк болон санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллага (мобайл мөнгөний данс гэх мэт)	32
2.5.5	Эд хөрөнгийн улсын бүртгэл (Government asset registries)	33
2.5.6	Хуулийн этгээдийн улсын бүртгэл (Corporate registries)	33



2.5.7	Хөрөнгийн биржийн бүртгэл (Stock exchange registries)	34
2.5.8	Барилга байгууламжид нэгжлэг хийх	34
2.5.9	Хуулиар тогтоосон эд хөрөнгийг ил мэдээлэх тухай эрх зүйн зохицуулалт	37
2.5.10	Сэжигтнээс мэдүүлэг авах	37
2.5.11	Тандалт ажиглалт хийх (Surveillance)	38
2.5.12	Олон улсын мэдээллийн эх сурвалж	38

### **3 Эх үүсвэр болон зарцуулалтын дүн шинжилгээ хийж үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эсэхийг тогтоох нь** **39**

<b>3.1</b>	<b>Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийх нь (тохиолдлын жишээн дээр)</b>	<b>40</b>
<b>3.2</b>	<b>Анхаарвал зохих хугацааг сонгох нь (Selecting period of interest)</b>	<b>45</b>
3.2.1	Анхаарвал зохих хугацааг тогтооход хуульд заасан хязгаарлалт байдаг уу?	45
3.2.2	Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн ямар эд хөрөнгийн төрлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд авч үздэг вэ?	46
3.2.3	Тухайн этгээд тодорхой хугацаанд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэдгийг илтгэх улаан туг буюу анхааруулсан шинж тэмдэг байдаг уу?	46
3.2.4	Тухайн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг нарийн нягталж шалгасан/шалгаагүй үлдсэн цаг хугацаа байна уу?	47
3.2.5	Тухайн этгээд сүүлд мөрийг нь олох боломжгүй болсон их хэмжээний бэлэн мөнгө гаргаж авсан уу?	47
3.2.6	Тодорхой хугацаа хүртэл хадгалуулсан хөрөнгийг үнэн зөвөөр тогтоох боломжтой юу?	49

1

Эх үүсвэр ба  
зарцуулалтын  
дүн  
шинжилгээний  
талаарх  
танилцуулга

## 1.1 “Мөнгөн хөрөнгийн эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ” гэж юу вэ?

Мөнгөн хөрөнгийн эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ (Source and Application of Funds Analysis) (цаашид “эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ” гэх) гэдэг нь тогтоосон хугацаан дахь тухайн этгээдийн санхүүгийн бүх орлого, зарлагын үнэлгээ юм.

Энэхүү дүн шинжилгээний аргыг арилжааны орчинд<sup>1</sup> түгээмэл ашигладаг хэдий ч үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой нөхцөл байдалд ашиглах боломжтой сайн арга хэрэгсэл бөгөөд дараах зүйлийг оновчтой, шударгаар нотлоход ашиглаж болно. Үүнд:

1. Тухайн хүн тодорхой хэмжээний хөрөнгө чинээтэй байсан;<sup>2</sup>
2. Энэхүү хөрөнгө чинээний хууль ёсны гарал үүслийг тухайн хүний хууль ёсны орлогоор тайлбарлах боломжгүй байх.

Өөрөөр хэлбэл, эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг мөрдөгч, прокурорууд ашиглан **үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжийн нийтлэг хоёр бүрэлдэхүүн хэсэг** болох хөрөнгө чинээний бүрэлдэхүүн хэсэг болон хангалтгүй орлогын бүрэлдэхүүн хэсгийг тогтооход ашиглах боломжтой (дэлгэрэнгүй мэдээллийг Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлагын 3 дугаар бүлгээс үзнэ үү).

### **“Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр” болон “зарцуулалт”-ыг тогтооход санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа ашиглах хэрэгцээ шаардлага**

Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулийн нийтлэг хоёр бүрэлдэхүүн хэсэг тогтоогдсон эсэхийг шалгахын тулд шүүхээс шаарддаг үндсэн хоёр мөнгөн дүнг тогтоох зорилгоор эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхэд эхлээд санхүүгийн нарийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэрэгтэй болдог. Эдгээр хоёр мөнгөн дүн нь:

1. Тухайн хөрөнгө чинээг (wealth) олж авах, тогтоосон хугацаанд уг хөрөнгө чинээний үр шимийг хүртэхэд зарцуулсан мөнгөн хөрөнгийн

1 “Мөнгөн гүйлгээний” дүн шинжилгээ эсхүл “мөнгөн хөрөнгийн эх үүсвэр, ашиглалт”-ын дүн шинжилгээ гэж нэрлэдэг.

2 Энэ агуулгын хүрээнд “хөрөнгө чинээ” гэдэгт юуг оруулах нь тухайн улсын хууль тогтоомжоос хамаарах боловч ихэнхи тохиолдолд уламжлалт биет хөрөнгийг олж авах, үр шимийг хүртэх, түүнчлэн амьдралын хэв маягтай холбоотой тав тухтай байдал, үйлчилгээ авах, тэр ч байтугай бусад этгээдэд бэлэг өгөх чадварыг багтаадаг.

(fund) хэмжээгээр тодорхойлогдох (мөн тухайн хугацаанд “хадгалсан” нийт мөнгөн хөрөнгийн дүнг оруулна) **тухайн хүн үр шимийг нь хүртэж байсан нийт хөрөнгө чинээний дүн.**

2. Ижил хугацаанд тэдгээр хөрөнгө чинээг олж авах, үр шимийг хүртэхэд (эсхүл уг хадгаламжийг үүсгэхэд) хэрэглэсэн байж болох тухайн этгээдийн хүлээн авсан эсхүл хүлээн авах боломжит (available) орлогын **мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрийн** нийт дүн.

Дээр дурдсан эхний мөнгөн дүнд хамаарах мөнгөн хөрөнгийг хэн нэгэн ашиглаж, зарцуулж, хуримтлуулсан тохиолдлыг **ЗАРЦУУЛАЛТ** гэж нэрлэнэ.

Хэн нэгэн мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс мөнгөн хөрөнгө хүлээн авсан тохиолдлыг **ОРЛОГЫН МЭДЭГДЭЖ БУЙ ХУУЛЬ ЁСНЫ ЭХ ҮҮСВЭР** гэж нэрлэнэ.

Биет хөрөнгө (амины орон сууц, тээврийн хэрэгсэл, компанийн хувьцаа гэх мэт) худалдаж авах эсхүл зээлийн эргэн төлөлтөд тухайн этгээдийн зарцуулсан зарлага нь “Зарцуулалт”-ын нийтлэг жишээ болно. Хөдөлмөр эрхэлж олсон цалин хөлс, өв залгамжлалаар олсон хөрөнгө, хууль ёсны гэрээний дагуу олгосон аливаа зээл нь “Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр”-ийн нийтлэг жишээ болно. Дүн шинжилгээ хийх хугацаанаас өмнө хүлээн авсан орлогыг мөн энэ хугацааны эхэнд банкны дансанд хадгалуулсан хадгаламж хэлбэрээр тооцно. Эсрэгээр нь, дүн шинжилгээ хийх хугацаанд банкны дансанд мөнгө хуримтлуулах нь мөнгөн хөрөнгийн зарцуулалт гэж тооцогддог бөгөөд уг хугацааны сүүлийн өдөр тухайн банкны дансанд байгаа мөнгөн хөрөнгийн хэмжээгээр илэрнэ.

### **Эх үүсвэр ба зарцуулалтын томьёо**

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд зарцуулалтын нийт хэмжээ болон орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрийн нийт хэмжээг тодорхойлсны дараа эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний эцсийн шатанд энгийн томьёо ашиглан эдгээр хоёр үзүүлэлтийг харьцуулж тухайн этгээд тодорхой хугацааны туршид **орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс үүссэн байх боломжгүй** хөрөнгийг ашигласан/зарцуулсан эсхүл хадгалсан эсэхийг тодорхойлно. Энэхүү томьёог дараах байдлаар томъёолно:

### Зарцуулалт

Тухайн этгээд хөрөнгө чинээ олж авах, ашиглах зорилгоор хэрэглэсэн эсхүл тодорхой хугацааны туршид хадгалсан нийт мөнгөн хөрөнгийн дүн

—

(хасах нь)

### Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр

Уг хугацаанд хөрөнгө чинээ олж авах, үр шимийг хүртэх эсхүл **хадгаламжид хуримтлуулахад** хэрэглэх боломжтой тухайн хүний хүлээн авсан эсхүл авах боломжит мэдэгдэж буй **хууль ёсны эх үүсвэрээс олж авсан** нийт мөнгөн хөрөнгийн дүн

=

(тэнцүү)

### Нийт үндэслэлгүй хөрөнгөжилт

Тухайн этгээд хөрөнгө чинээ олж авах, үр шимийг хүртэх эсхүл хадгаламж хэлбэрээр хуримтлуулахад зарцуулсан мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс орж ирээгүй нийт мөнгөн хөрөнгийн дүн

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн этгээдийн бүх хууль ёсны орлого, гарсан бүх зарцуулалт нь тогтоогдсон бөгөөд тухайн этгээд хууль бус эх үүсвэрээс мөнгөн хөрөнгө **аваагүй** бол ... уг томъёоны хариу үргэлж **тэг** байх болно.

Хэрэв, тухайн этгээд тодорхойгүй/хууль бус эх үүсвэрээс мөнгөн хөрөнгө хүлээн **авч**, ашигласан/хэрэглэсэн бол... гарах хариу нь **зерэг** тоо гарч ирэх бөгөөд энэ нь тухайн этгээдийн тодорхойгүй/хууль бус эх үүсвэрээс авсан байж таарах нийт мөнгөн хөрөнгийн хэмжээтэй тэнцүү байх болно.

Нөгөө талаас, хэрэв сөрөг тоо гарвал энэ нь тухайн этгээд мөнгөө ашигласан эсхүл хадгалсан бүх тохиолдлыг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлж тогтоогоогүй байна гэсэн үг юм.<sup>3</sup>

Тухайлбал, хэрэв анх хуримтлалгүй байсан хүний талаар дараах зүйлсийг нотолж чадвал:

3 “Тухайн этгээдийн тодорхой хугацаанд хөрөнгө чинээ олж авах, үр шимийг хүртэхийн тулд ашигласан мөнгөн хөрөнгийн нийт дүн”-д тэр хүлээн авсан мөнгөн хөрөнгөө “ашигласан” тохиолдол бүрийг оруулах ёстой БӨГӨӨД түүний виртуал хөрөнгө эсхүл бэлэн мөнгө хэлбэрээр “хадгалсан” мөнгөн хөрөнгийг тусгах ёстой. Хэрэв, тооцооллын үр дүнд сөрөг тоо гарвал энэ нь боломжгүй үр дүнг илэрхийлнэ: тухайн хүн ашигласан эсхүл хадгалсан хэмжээнээсээ илүү орлого олсон байна. Мөрдөн шалгах ажиллагааны дараа уг тооцоолол сөрөг гарсан бол энэ нь мөрдөн шалгах ажиллагааны явцад түүний мөнгөө “ашигласан” эсхүл “хадгалсан” бүх арга замыг илрүүлээгүй гэсэн үг юм. Энэ нь байж болох зүйл юм, ялангуяа тухайн этгээд нь бэлэн мөнгө байнга ашигладаг бол ийм төрлийн гүйлгээг нотлоход хэцүү байдаг.

- Тэр 12 сарын хугацаанд хуулийн дагуу нийт 20,000 ам.долларын орлого олсон;
- Тэр амьдралынхаа ердийн хэв маягийг хадгалахад мөн хугацаанд 10,000 ам.доллар зарцуулсан; бөгөөд
- Тухайн хугацаанд банкны дансандаа 10,000 ам.доллартой үлдсэн ...


...энэ тохиолдолд тухайн этгээд зөвхөн хууль ёсны эх үүсвэрээр авсан мөнгийг ашиглаж, хадгалсан тул дээрх томъёогоор тооцсон хариу тэг гарна.



Харин үүний оронд дараах зүйлийг нотолбол:

- Тэр хууль ёсны эх үүсвэрээс 12 сарын хугацаанд нийт 20,000 ам.доллар олсон, мөн
- Тэр тухайн жилийн турш амьдралынхаа хэв маягийг хадгалахад ямар нэгэн байдлаар 30,000 ам.доллар зарцуулсан; бөгөөд
- Тухайн хугацаанд банкны дансандаа 40,000 ам.доллартой үлдсэн...

..... энэ тохиолдолд дээрх томъёог ашигласан тооцооллоор эерэг тоо гарах бөгөөд энэ нь уг хугацаанд тухайн этгээд тодорхойгүй/хууль бус эх үүсвэрээс мөнгө хүлээн авсан байж таарахыг харуулж байна:



Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг ихэвчлэн Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгт хэлбэрээр танилцуулж, тухайн этгээдийн Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр, мөн түүний зарцуулалтыг харуулсан хоёр дүнг харьцуулсан байдаг.

Тухайлбал, Эх үүсвэр ба зарцуулалтын маш энгийн хүснэгт нь дараах хэлбэртэй байж болно:

<b>Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ (2020.01.01–2020.06.30)</b>			
<b>Мөнгөн хөрөнгийн мэдэгдэж буй эх үүсвэр (орлого)</b>		<b>Мөнгөн хөрөнгийн зарцуулалт (хөрөнгө чинээ)</b>	
Банкны дансны үлдэгдэл (2020.01.01)	10,000	Банкны дансны үлдэгдэл (2020.06.30)	70,000
Цалин (6 сар)	30,000	Байшин худалдаж авахад	120,000
Х банкнаас авсан зээл	40,000	Х банкнаас олгосон зээлийн эргэн төлөлт	5,000
Өвлөж авсан хөрөнгө	5,000	Автомашин худалдаж авахад	50,000
<b>Мөнгөн хөрөнгийн нийт мэдэгдэж буй эх үүсвэр</b>	<b>85,000</b>	<b>Нийт зарцуулалт</b>	<b>245,000</b>
(хасах нь)			
		<b>Мөнгөн хөрөнгийн нийт мэдэгдэж буй эх үүсвэр</b>	<b>85,000</b>
(тэнцүү)			
		<b>Мөнгөн хөрөнгийн нийт үл мэдэгдэх эх үүсвэр (үндэслэлгүй хөрөнгөжилт)</b>	<b>160,000</b>

Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхдээ авч үзэж болох олон янзын бүрэлдэхүүн хэсгийн талаар илүү дэлгэрэнгүй шинжилгээг энэхүү хавсралтын 2 дугаар бүлэгт оруулав. Дээрхтэй адил Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтийг хэрхэн үүсгэхийг харуулсан жишээг энэхүү хавсралтын 3 дугаар бүлэгт оруулав.

## 1.2 Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг авч үзсэн/хэрэглэсэн шүүхийн практик

Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнтэй холбоотой томоохон хэрэгт “Эх үүсвэр ба зарцуулалт”-ын дүн шинжилгээг тусгайлан тодорхойлж, дурдаагүй байдаг ч энэхүү дүн шинжилгээний аргын үндсэн зарчмуудыг дэлхий дахинаа үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гол хэргүүдэд ашигласан буюу эш татсан байдаг. Тухайлбал, *Ernest Percival Max Hunt v the Queen*<sup>4</sup> (Хонконг) and *Krishnanand v The State of Madhya Pradesh*<sup>5</sup> (Энэтхэг) нартай холбогдох чухал шийдвэрүүдэд шүүх тодорхой хугацааны орлогыг зарлагатай нь жишиж харьцуулан нарийн тооцоолол хийж, эдгээр хоёр тооны үл нийцэлд үндэслэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнийг тогтоосон. Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний арга нь эдгээр болон бусад хэрэг дээр авч үзсэн тооцооллын зарчмуудад тулгуурладаг бөгөөд мөрдөгч, прокурорууд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эсэхийг нотлоход ашиглаж болох тодорхой бөгөөд ойлгомжтой аргачлалаар хангадаг.

Эх үүсвэр ба зарцуулалт нь тухайн этгээдийн санхүүгийн байдлыг тодорхойлох цорын ганц дүн шинжилгээний арга биш болохыг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, АНУ-д татварын зөрчилд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Цэвэр өртгийн дүн шинжилгээний (Net Worth Analysis) аргыг түгээмэл ашигладаг.<sup>6</sup>

---

4 Ernest Percival Max Hunt v the Queen [1974] HKCA 111

5 Krishnanand v The State of Madhya Pradesh MANU/SC/0134/1976

6 Цэвэр өртгийн дүн шинжилгээний аргын талаарх дэлгэрэнгүй тайлбар, гарын авлагыг АНУ-ын Хууль зүйн яамны Эрүүгийн татварын гарын авлагын 31-р бүлгээс үзнэ үү (АНУ-ын Хууль зүйн яамны Татварын хэлтэс, Эрүүгийн татварын гарын авлага, АНУ-ын Хууль зүйн яам, Вашингтон хот, 2020, <https://www.justice.gov/tax/page/file/1312166/download> цахим хуудаснаас үзэх боломжтой)



### 1.3 Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд яагаад хэрэгтэй байдаг вэ?

Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь мөрдөгч, прокуроруудад үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эсэх талаар тодорхой ойлголтыг өгөх боломжтой. Иймд энэ төрлийн дүн шинжилгээг үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой бүх мөрдөн шалгах ажиллагааны явцад анхаарч үзэх хэрэгтэй юм, учир нь уг дүн шинжилгээнээс мөрдөгч, прокурорууд шүүх хурлаар **ялах магадлал хэр байхыг сайтар үнэлэх** боломжийг олгох мэдээлэл олж авдаг<sup>7</sup>. Түүнчлэн, хэрэв эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг сайтар хийж, тухайн этгээдийн олж авсан хууль ёсны орлогын байж болох бүх эх үүсвэрийг хамруулсан бол энэхүү дүн шинжилгээ нь тухайн этгээдийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх үндэслэлийг шүүхэд тайлбарлах эсхүл **түүнийг эсэргүүцсэн болзошгүй хуурамч мэдүүлгийг няцаах хангалттай нотлох баримтыг прокурорт өгөх болно.**

Тухайн этгээдийн хууль ёсны орлогын зарим эсхүл бүх эх үүсвэрийг (тухайлбал, үндсэн гарын авлагын 3.2.3-т заасан хууль тогтоомж) тогтоох, нотлох баримт бүрдүүлэх үүргийг төрд хүлээлгэдэггүй улс орнуудад ч гэсэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг мөрдөн шалгах явцад эх үүсвэр болон зарцуулалтын дүн шинжилгээг анхаарч үзэх хэрэгтэй байдаг. Эдгээр улсуудад тухайн этгээдийн орлогыг нотлох баримтыг төрөөс цуглуулах, гаргаж өгөх шаардлага байдаггүй ч тухайн этгээдийн нийт хөрөнгө чинээг тодорхой хугацааны туршид олсон нийт орлоготой нь харьцуулсан эх үүсвэр ба зарцуулалтын нарийвчилсан дүн шинжилгээ хийх нь практикт нэн тустай байсаар байна. Энэ нь үндэслэл дутмаг, нотлох баримт тааруухан хэргийг мөрдөн шалгахад нөөц бололцоог дэмий үрэхгүй байх баталгаа болж өгдөг.

7 Бодит байдалд прокурорууд эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийсний дараа л зөвхөн тухайн хүний орлого болон зарцуулалтын хооронд ихээхэн хэмжээний зөрүүтэй байх тохиолдолд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэрэгтэй. Хэрэв, зөрүүтэй байдал маш бага хэмжээтэй байвал энэ нь шүүхийн нэхэмжлэл амжилттай болох боломжийг эрс бууруулдаг.

## **1.4 Үндэслэлгүйгээр хөрөнгөжих бүх хэрэг дээр эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ тохиромжтой байдаг уу?**

Ихэнх тохиолдолд Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь маш хэрэгтэй байдаг ч үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэргийн тохиолдол бүр өвөрмөц гэдгийг анхаарах нь зүйтэй. Тиймээс зарим тохиолдолд эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийх нь үр дүн багатай байж болно. Нэг жишээ дурдахад, хэрэв тухайн этгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх хардлагыг төрүүлж банкны дансандаа их хэмжээний бэлэн мөнгө байршуулж, улмаар дээрх бэлэн мөнгийг буцаан авч, илрүүлэх боломжгүй зориулалтаар ашигласан байна. Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь энэ тохиолдолд тохиромжгүй байж болно. Учир нь бэлэн мөнгө авахыг зарцуулалт гэж үздэггүй, харин зөвхөн тодорхой арга хэлбэрээр эсхүл тодорхой нотлох боломжтой тохиолдлыг авч үздэг. Энэ нь хөрөнгийг давхардуулж тоолох, сэжигтэнг шударга бусаар авч үзэхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Ийм тохиолдолд мөрдөгч нар хувь хүний дансандаа байршуулсан бэлэн мөнгө нь хууль ёсны эх үүсвэрээс орж ирээгүй гэдгийг тохиолдол бүрээр нотлоход анхаарлаа хандуулах нь илүү оновчтой байх болно.

# 2

Эх үүсвэр ба  
зарцуулалтын  
дүн шинжилгээнд  
ашиглах мэдээлэл  
цуглуулах  
зорилгоор  
санхүүгийн мөрдөн  
шалгах ажиллагаа  
явуулах нь

“Хэргийн нөхцөл байдлыг бүрэн тогтоохын тулд яллагч тал яллагдагчийн санхүүгийн түүхийг бүрдүүлэх шаардлагатай” Uganda v B.D Wandera НСТ-00-АС-SC-0012/2014

Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь санхүүгийн нарийвчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулахыг шаарддаг бөгөөд мөрдөгч нь тодорхой тогтоосон хугацааны туршид буюу “анхаарвал зохих хугацаанд” хувь хүний санхүүгийн орлого, зарлагын иж бүрэн нарийвчилсан мэдээллийг цуглуулахыг эрмэлзэх хэрэгтэй. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхдээ анхаарвал зохих хугацааг заавал эхнээс нь тогтоох шаардлагагүй. Энэ нь тухайн этгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжиж байсныг тодорхойлох тогтоосон хугацаа бөгөөд нэлээд хэмжээний санхүүгийн нотлох баримт цуглуулсны дараа л энэ хугацааны хүрээ, хязгаарыг тодорхойлох боломжтой болно. Анхаарвал зохих хугацааг тогтоох аргыг энэ хавсралтын 3-р бүлэгт авч үзнэ.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа мөрдөгч дараах тохиолдлын дэлгэрэнгүй жагсаалтыг гаргахыг эрмэлзэх ёстой. Үүнд:

- Тухайн этгээд мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс (орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр) мөнгөн хөрөнгө хүлээн авсан байдал;
- Тухайн этгээд аливаа зорилгоор ашигласан/зарцуулсан/бэлэглэсэн мөнгөн хөрөнгө (зарцуулалт).

Энэ нь төвөгтэй ажил мэт санагдаж болох ч эдгээр мэдээллийг олж авч болох олон төрлийн ердийн эх сурвалж байдаг. Мөрдөгч боломжтой бол мөрдөн шалгах ажиллагаа явуулах бүртээ эдгээр эх үүсвэрийг нарийвчлан шүүрдэх хэрэгтэй.

Тухайн улсын эдийн засаг өргөн хүрээнд цахимжсан байна уу эсхүл бэлэн мөнгө, цаас давамгайлсан байна уу гэдгээс үл хамааран энэ ажлыг хийх хэрэгтэй.

Мэдээж мөрдөгч хэр хэмжээний санхүүгийн мэдээлэл цуглуулж болохыг цаг хугацааны боломж болон хууль тогтоомж тодорхойлно. Тухайлбал, ихэнх банкууд дансны мэдээллийг тодорхой хугацаанд л хадгалах зохицуулалттай байдаг. Гэсэн хэдий ч мөрдөгч нь хууль журмын дагуу бөгөөд бодит бололцооныхоо хүрээнд боломжтой бүхий л санхүүгийн мэдээллийг

цуглуулахыг эрэлхийлэх ёстой. Ингэснээр эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг хийхэд шаардлагатай дэлгэрэнгүй мэдээлэлтэй болж тогтоосон хугацаанд тухайн этгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эсэхийг үнэн зөв тодорхойлох боломжтой болно.

Энэ бүлэгт эхний ээлжинд дараах асуудлыг тайлбарлана. Үүнд:

- Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа мөрдөгчийн харгалзаж үзэх ёстой хууль ёсны орлогын нийтлэг төрлүүд.
- Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа мөрдөгчийн харгалзан үзэх ёстой зарцуулалтын нийтлэг төрлүүд.
- Нотлох баримтын дээрх 2 төрлийн нийтлэг эх сурвалж.

## 2.1 “Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр”-ийн нийтлэг жишээ

“Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр” гэдэг нь мөнгөн **хөрөнгө нь хууль ёсны арга замаар тухайн этгээдийн хяналт, эзэмшил, өмчлөлд орсон** гэдэг нь нотлогдох жишээ юм. Өөрөөр хэлбэл, анхаарвал зохих хугацаанд аливаа зорилгоор ашиглах боломжтой байсан мөнгөн хөрөнгийн хэмжээ үүнд хамаарна (жишээлбэл, биет болон биет бус эд зүйлийг худалдан авах). Орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр гэдэгт дараах зүйлс хамаарч болно. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэн хугацаанд хууль ёсны хөдөлмөрийн гэрээгээр төрийн албан хаагчаар ажиллаж байх хугацаандаа хүлээн авсан цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал;
- Тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн хугацаанд цалин хөлс, бүртгэлтэй хязгаарлагдмал хувьцаат компани болон тухайн этгээдийн ажилладаг эсхүл хувь эзэмшдэг нээлттэй компаниас авсан ашиг, ногдол ашиг хэлбэрээр олсон орлого;
- Анхаарвал зохих хугацаанд хийгдсэн хөрөнгө худалдах арилжаанаас (мал амьтан, тээврийн хэрэгсэл, үл хөдлөх эд хөрөнгө гэх мэт) олсон орлого;
- Анхаарвал зохих хугацаанд тухайн этгээдийн өвлөн авсан өв хөрөнгө;
- Өмч/хөрөнгө (амины орон сууц, тээврийн хэрэгсэл гэх мэт) түрээслүүлснээс олсон аливаа түрээсийн орлого<sup>8</sup>;
- Баталгаажсан зээлийн гэрээний дагуу тухайн этгээдэд анхаарвал зохих хугацаанд олгогдсон зээл;
- Анхаарвал зохих хугацаанд хүлээн авсан хууль ёсны эх үүсвэрээс эхтэйг тогтоох боломжтой аливаа мөнгө (бэлэг, сугалааны хонжвор, даатгал, нөхөн төлбөр гэх мэт);
- Анхаарвал зохих хугацааны эхэнд тухайн этгээдийн эзэмшиж байсан банкны данс, мобайл мөнгөний дансанд хадгалагдаж байсан аливаа мөнгө (үүнийг энэ хавсралтын 2.3-т дэлгэрэнгүй тайлбарласан болно).

---

8 Энэ нь тухайн этгээд анхаарвал зохих хугацаанд олж авсан өмчид хамаарахгүй байж болохыг анхаарах нь зүйтэй. Учир нь хэрэв шүүх тухайн өмчийг анх худалдан авахад зарцуулсан мөнгөн хөрөнгө ноттойгоор хууль ёсны эх үүсвэрээс гаралтайг тогтоож чадахгүй бол эдгээр өмчийн түрээсийн орлогыг гэмт хэргийн гаралтай орлого гэж үзэж болох юм.

Хэрэв тухайн этгээд гэрлэсэн, эсхүл өмч хөрөнгөө дундаа өмчилдөг харилцаатай бол тухайн этгээдийн эхнэр, нөхрийн буюу гэрлэгчийн хууль ёсны орлогыг мөн мөрдөгч тогтоож, тухайн этгээдийн хууль ёсны орлогод оруулан тооцох ёстой. Анхаарвал зохих хугацаанд сэжигтэн нь гэрлэгчийн орлогыг биет болон биет бус эд хөрөнгө худалдаж авахад зарцуулах боломжтой байсан гэж үзэж болно (үгүйсгэх нотлох баримт байхгүй тохиолдолд).

Мөрдөгч нь тухайн этгээд анхаарвал зохих хугацаанд олсон бүх хууль ёсны орлогыг тогтоохыг оролдох нь чухал юм. Учир нь ***мөрдөгч тухайн этгээд анхаарвал зохих хугацаанд хүлээн авсан, болон авах боломжтой байсан хууль ёсны орлогын бүхий л эх үүсвэрийг тогтоож чадвал тухайн этгээд нь эдгээр орлогын нийт дүнгээс давж, хэтэрсэн мөнгийг олж авсан эсхүл ашигласан гэх тайлбарыг хийх боломж математикийн хувьд үгүй болох юм.***

Тухайлбал, тухайн этгээдийн хэт их зарлага гаргасны цорын ганц зөвтгөх шалтаг нь түүний бүрэн өмчилдөг хувийн бизнесээсээ олсон орлого (нийтлэг хэрэглэдэг шалтаг) бол:

- Мөрдөгч тухайн этгээд анхаарвал зохих хугацаанд уг бизнесээс олсон орлогын дүнг яг тодорхой тогтоосон бөгөөд...
- Мөрдөгч уг хугацааны тухайн этгээдийн хууль ёсны нийт орлогыг тооцохдоо энэхүү орлогыг оруулсан бөгөөд...
- Мөрдөгчийн хийсэн Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний ерөнхий дүнгээр сэжигтэн анхаарвал зохих хугацаанд энэхүү нийт орлогын нийлбэр дүнгээс илүү их хэмжээний мөнгөн хөрөнгө ашигласан нь тогтоогдвол...
- ***Сэжигтэн энэ хугацаанд зарцуулсан их хэмжээний мөнгөн хөрөнгийг бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлого гэж тайлбарлах боломжгүй болно.***

## 2.2 “Зарцуулалт”-ын нийтлэг жишээ

“Зарцуулалт” гэдэг нь тухайн этгээд аливаа зорилгоор мөнгөн хөрөнгийг ашигласан тохиолдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд өөрийн болон бусдын ашиг тусын тулд мөнгөн хөрөнгөө зарцуулсан эсхүл тодорхой мөнгөн хөрөнгийн өмчлөлөөс татгалзсан (жишээ нь, бэлэглэх гэх мэтээр) аливаа тохиолдлыг зарцуулалтад оруулна.

Зарцуулалт нь тухайн этгээдийн олж авсан хөрөнгө эсхүл хүлээн авсан үйлчилгээ биш гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Харин тухайн этгээд уг хөрөнгө, үйлчилгээг авахад ашигласан мөнгөн хөрөнгийг хэлж байгааг анхаарах нь чухал. Тухайлбал, хэрэв тухайн этгээд анхаарвал зохих хугацаанд тус бүр 500,000 ам.долларын үнээр гурван амины орон сууц худалдаж авсан бол эдгээр орон сууцыг худалдаж авахад зарцуулсан мөнгийг дүн шинжилгээ хийх зорилгоор “зарцуулалт” гэж үзнэ. Эдгээр орон сууц цаг хугацааны явцад үнэ цэнэ нь нэмэгдэж эсхүл буурч байсан ч Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхэд шаардлагатай дүнгийн хэмжээ нь зөвхөн уг хөрөнгийг худалдаж авахад төлсөн нийт дүн хэвээр байна. Энэ нь дэлхий дахинаа хэрэглэгдэж буй үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийн үнэлгээний арга зүйтэй ижил байна<sup>9</sup>.

Үндсэндээ хэрэв тухайн этгээд ямар нэгэн зүйл худалдаж авсан, мөнгө бэлэглэсэн, эсхүл эзэмшиж байсан мөнгөө шилжүүлсэн бол мөрдөгч иймэрхүү худалдан авалт, бэлэглэл, шилжүүлэг явагдсан болохыг нотолж чадвал үүнийг зарцуулалт гэж үзнэ.

Түүнчлэн, анхаарвал зохих хугацааны сүүлийн өдөр тухайн этгээдийн дансанд үлдсэн бүх мөнгийг зарцуулалтад тооцно. Учир нь тэдгээр дансны үлдэгдэл дэх мөнгөн дүн нь анхаарвал зохих хугацааны туршид тухайн этгээдийн хадгаламждаа төвлөрүүлж байсан орлогын нийлбэр дүнг илэрхийлэх бөгөөд уг хугацааны дараа ч зарцуулах боломжтой байна. Үүнийг энэхүү Хавсралтын 2.3-т илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

Орлого тооцохтой нэгэн адил хэрэв тухайн этгээд гэрлэсэн эсхүл хөрөнгөө хамтран эзэмшдэг харилцаатай бол тухайн этгээдийн эхнэр/нөхөр/ хамтрагчийн ашигласан мөнгийг мөн зорилтот этгээдийн ашигласан мөнгөнд тооцох ёстой. Түүнчлэн, хэрэв тухайн этгээд өөр хүний тусын тулд мөнгөн хөрөнгөө ашигласан, тухайлбал ахынхаа нэр дээр амины орон сууц худалдаж

---

9 Сэжигтний худалдаж авсан тодорхой хөрөнгийн худалдан авалтын дүнгийн бүртгэл байхгүй онцгой нөхцөлд, тухайн хөрөнгийг худалдан авах үеийн зах зээлийн үнэ ханшийг дүн шинжилгээ хийх зорилгоор зарцуулалтын дүн гэж ашиглаж болно. Гэхдээ шүүх хурлын явцад энэхүү дүн үндэслэлтэй байх шаардлагатай бөгөөд магадгүй шинжээч гэрчийн тусалцаатайгаар тайлбарлагдах ёстой бөгөөд үнэн зөв, оновчтой эсэхийг шүүх шийдвэрлэнэ.



авсан, аль нэг байгууллагад их хэмжээний хандив өгсөн бол эдгээр гүйлгээг мөн тухайн этгээдэд хамаарах зарцуулалт гэж тооцох ёстой.

Зарцуулалтын ангилалд хамаарах нийтлэг зүйлс нь дараах тохиолдолд хамаарах мөнгөн хөрөнгө нотлогдох боломжтой байхыг ойлгоно:

- Үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл зэрэг биет эд хөрөнгө худалдаж авахад зарцуулсан;
- Түрээсийн төлбөр төлөхөд ашигласан;
- Зээлийн гэрээний дагуу буцаан төлөлт хийхэд ашигласан;
- Хэрэглээний төлбөр (цахилгаан, ус, утасны төлбөр гэх мэт) төлөхөд ашигласан;
- Сургалтын төлбөр төлөхөд ашигласан;
- Зээлийн картын төлбөрт ашигласан;
- Татвар төлөхөд ашигласан;
- Банкны данс эсхүл мобайл мөнгөний данснаас тухайн иргэн болон түүний эхнэр/нөхөр/хамтрагчийн эзэмшилд байдаггүй данс руу цахим шилжүүлэг хийхэд ашигласан<sup>10</sup>;
- Хандив болон бусад бэлэг дурсгалд ашигласан;
- Хөлсний ажилчдад (гэрийн үйлчлэгч гэх мэт) цалин хөлс олгоход ашигласан;
- Үнэт эдлэл худалдан авахад ашигласан;
- Амралтын зардал төлөхөд ашигласан;
- Сэжигтний биед нэгжлэг хийх үеэр бэлэн мөнгө хэлбэртэйгээр хураагдсан;
- Тогтоосон гэмт хэргийн хугацаа дуусах өдөр сэжигтний эзэмшлийн банкны болон мобайл мөнгөний дансанд байсан.

Гэхдээ хэрэв сэжигтэн анхаарвал зохих хугацаанд банкны данснаасаа мөнгө бэлнээр авсан бол ийнхүү мөнгө гаргаж авсныг зарцуулалтад тооцохгүй, учир нь тухайн этгээд гаргаж авсан бэлэн мөнгийг хянасан хэвээр байна. Мэдээжийн хэрэг, хэрэв сэжигтэн авсан бэлэн мөнгөө дараа нь зарцуулсан, бусдад өгсөн гэдгийг нотлох баримт байгаа бол уг гүйлгээг зарцуулалтад тооцож болно. Бэлэн мөнгө гэх сэдвийг энэхүү Хавсралтын 2.4-т дэлгэрэнгүй тайлбарласан болно.

10 Хэрэв тухайн этгээд (эсхүл түүний эхнэр, нөхөр)-ийн эзэмшдэг нэг данснаас түүний (эсхүл түүний эхнэр, нөхөр) эзэмшдэг өөр нэг данс руу мөнгө шилжсэн бол техникийн хувьд энэ мөнгөн хөрөнгө нь түүний (эсхүл эхнэр, нөхөр) эзэмшилд хэвээр байгаа бөгөөд үүнийг зарцуулалтад тооцох ёсгүй. Мэдээжийн хэрэг, хэрэв анхаарвал зохих хугацааны сүүлийн өдөр дансанд мөнгө үлдсэн бол эдгээр хөрөнгийг зарцуулалт гэж тооцож болно.

## 2.3 Эх үүсвэр ба зарцуулалтын тусгай дэд зүйл: Анхаарвал зохих хугацаанаас өмнө болон уг хугацаанд “хадгалсан” эсхүл “хуримтлуулсан” мөнгөн хөрөнгө

Орлого/зарцуулалтын нэмэлт тайлбар шаардах тусгай дэд зүйл нь тухайн хүний дансанд байгаа мөнгөн хөрөнгө юм.

Энэ хэсгийн эхэнд дурдсанчлан, тухайн этгээд хууль ёсны дагуу ашиглах боломжтой мөнгөн дүнгээс илүү их мөнгө ашигласан эсэхийг тодорхойлохын тулд Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний дагуу түүний тодорхой хугацааны туршид хуримтлуулсан хууль ёсны орлогыг мөн хугацаанд хийсэн зардал, хуримтлалтай харьцуулдаг. Энэ нь мөрдөгчөөс гэмт хэрэг үйлдэх хугацаа буюу “анхаарвал зохих хугацаа”-г тогтоож уг хугацаа эхлэх, дуусгавар болох өдрийг тодорхой тогтоохыг шаардана. Түүнчлэн, Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь мөрдөгчөөс уг хугацаа эхлэх өдрөөс өмнө сэжигтний олсон бүх орлогыг хууль ёсны дагуу олж авсан гэж таамаглахыг (үнэн зөв эсэхээс үл хамааран) шаардах бөгөөд уг хугацааг эхлэхээс өмнө эдгээр орлогоос хуримтлуулсан аливаа хуримтлалыг хуулийн дагуу олсон гэж үзэхийг мөн шаардах болно. Тухайн этгээд анхаарвал зохих хугацаанаас өмнө орлого олж авсан байх магадлал өндөр бөгөөд Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхдээ эдгээр орлогыг тооцох нь шударга бөгөөд оновчтой зүйл болно. Гэхдээ анхаарвал зохих хугацаанаас өмнө ердийн амьжиргааны зардалд эдгээр орлогын нэлээд хэсгийг зарцуулсан байж таарах тул эдгээр орлогыг бүхэлд нь авч үзэх нь оновчгүй юм. Иймд, тухайн этгээдийн анхаарвал зохих хугацаанаас өмнө олж авсан орлогоосоо хуримтлуулсан нийт **хуримтлалын** дүнг л тооцох нь зөв. Учир нь энэ нь анхаарвал зохих хугацааны үед тухайн этгээдэд ашиглах боломжтой байсан өмнөх орлогоос олсон нийт мөнгөн хөрөнгийн дүнтэй тэнцэх юм.

Тухайн хүний мөнгөн хадгаламж нь банк болон мобайл мөнгөний дансанд цахим хэлбэрээр эсхүл бэлэн мөнгө гэсэн хоёр хэлбэртэй байж болно (бэлэн мөнгөний хадгаламжийг хэрхэн авч үзэх тухай тайлбарыг доорх 2.4 дэх хэсгээс үзнэ үү). Иймд мөрдөгч тухайн этгээдийн эзэмшиж буй аливаа данснаас анхаарвал зохих хугацаа эхлэх өдрийн дансны үлдэгдлийг харуулсан хуулгыг авах нь чухал юм. Учир нь энэ нь анхаарвал зохих хугацаа эхлэхээс өмнө олсон орлогоос тухайн этгээдийн хуримтлуулсан нийт хадгаламжийн дүнг илэрхийлэх болно.

Үүнээс эсрэгээр, хадгаламжид мөнгөө байршуулах нь тухайн этгээд орлогоо ашиглахаар сонгосон арга байж болох тул анхаарвал зохих хугацааны эцэст

тухайн этгээдийн дансанд байгаа мөнгөн хөрөнгийн хэмжээг зарцуулалт гэж үзэх ёстой. Энэ тоо нь үндсэндээ тухайн этгээдийн анхаарвал зохих хугацаанд хуримтлуулж чадсан цахим хэлбэрээр хадгалсан мөнгөний нийт дүнг илэрхийлнэ.

Тухайлбал, мөрдөгч тухайн жилийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сэжигтэнтэй холбоотой дүн шинжилгээ хийж байгаа бөгөөд уг этгээд нь банкны дансандаа дараах үлдэгдэлтэй бол...

- 1 дүгээр сарын 1-нд (12:00 цагт) – 100,000 ам.доллар
- 12 дугаар сарын 31-нд (23:59 цагт) – 500,000 ам.доллар

... Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний дагуу 100,000 ам.долларыг хууль ёсны орлого гэж үзэх ёстой (учир нь энэ мөнгө нь өмнө нь олж авсан орлогоосоо хэмнэж, анхаарвал зохих хугацаанд ашиглах боломжтой байсан нийт хөрөнгийн хэмжээг илэрхийлнэ). Харин, 500,000 ам.долларыг зарцуулалт гэж үзэх ёстой (учир нь энэ нь тухайн этгээдийн анхаарвал зохих хугацаанд хадгаламждаа хийсэн нийт мөнгөн дүнг илэрхийлнэ).

Мобайл мөнгөний дансанд байгаа аливаа мөнгөн хөрөнгийг мөн ижил байдлаар авч үзвэл зохино.

## 2.4 Эх үүсвэр ба зарцуулалтын тусгай дэд зүйл: тодорхойгүй эх үүсвэрээс орж ирсэн бэлэн мөнгө, тодорхой бус чиглэл рүү гарсан бэлэн мөнгө

Өмнөх хэсэгт дурдсан банк болон мобайл дансны үлдэгдлийн нэгэн адил, хэрэв тухайн этгээд анхаарвал зохих хугацаа эхлэхэд гартаа тодорхой хэмжээний бэлэн мөнгөтэй байсан гэдгээ нотолж чадвал үүнийг мөн анхаарвал зохих хугацаанд ашиглах боломжтой хадгаламж гэж үзэж, хууль ёсны орлогод тооцох ёстой. Эсрэгээр нь, хэрэв мөрдөгчид нэгжлэг хийхдээ тухайн этгээдээс тодорхой хэмжээний бэлэн мөнгө хураан авсан бол дансанд байгаа мөнгийг зарцуулалт гэж үздэг шиг уг “хөрөнгө”-ийг зарцуулалт гэж үзэх ёстой. Шууд утгаараа гарт байгаа бэлэн мөнгө нь мөнгөн хөрөнгийн зарцуулалт биш ч бэлэн мөнгө нь банкны дансанд байгаа мөнгө шиг тухайн этгээдийн хуримтлуулсан хөрвөх чадвартай мөнгө бөгөөд үүнийг тухайн хүний анхаарвал зохих хугацаанд олж авсан бусад хөрөнгийн нэгэн адил авч үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн хөрөнгийг олж авах зардал нь (энэ нь бэлэн мөнгөтэй ижил дүнтэй байх нь ойлгомжтой) тухайн этгээд мөнгөө “зарцуулах” хэлбэр гэж тооцогдох ёстой.

Хэрэв, сэжигтэн анхаарвал зохих хугацаанд банкны данснаас бэлэн мөнгө авсан бол эдгээр мөнгөн дүнг зарцуулалт гэж **үзэж болохгүй** гэдгийг анхаарах нь чухал. Учир нь тухайн этгээд банкны данснаас мөнгө авснаар тухайн мөнгөн хөрөнгийн хяналт алга болохгүй зүгээр л цахим мөнгийг биет мөнгө болгон хөрвүүлсэн болно. Энэхүү хатуу тайлбар нь Эх үүсвэр ба зарцуулалтын тооцооллын нэгдмэл байдлыг хангах, хөрөнгийг давхар тоолохоос урьдчилан сэргийлэх зорилготой юм. Мөрдөгчийн бодитоор нотолсон зарцуулалтыг л зөвхөн нийт зарцуулалтад оруулж тооцно. Хэрэв, бэлэн мөнгө гаргаж авсан бөгөөд мөрдөгч энэхүү мөнгө юунд зарцуулагдсаныг нотолж чадахгүй бол эдгээр авсан мөнгийг зарцуулалт гэж үзэх боломжгүй юм.

Үүнтэй нэгэн адил, хэрэв тухайн этгээд тодорхойгүй эх үүсвэрээс банкны дансанд тодорхой хэмжээний бэлэн мөнгө байршуулсан бол эдгээр эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгийг орлого гэж үзэх ёсгүй. Учир нь энэ мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь мэдэгдэхгүй, харин тухайн этгээд өөрийн хяналтад байсан бэлэн мөнгөө зүгээр л сольж бэлэн мөнгөнөөс цахим мөнгө рүү хөрвүүлсэн гэдэг нь мэдэгдэж байгаа болно.

Мэдээж, хэрэв мөрдөгч тухайн этгээдийн гаргаж авсан бэлэн мөнгийг хэрхэн зарцуулсныг нотлох эсхүл хадгалуулсан мөнгө нь ямар хууль ёсны эх үүсвэрээс гаралтайг нотолж чадвал энэ мөнгийг зарцуулалт, орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэр гэж үзэх нь ойлгомжтой.

### **Хүснэгт №1: Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуульд зөвхөн “ хөрөнгө болон өмч” олж авах талаар заасан бол юу болох вэ?**

Үндсэн гарын авлагын 2.2.2.2 дахь хэсэгт дурдсанчлан зарим үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуульд амьжиргааны түвшин, амьдралын хэв маягийг хадгалах зэрэг зардлын дэлгэрэнгүй тайлбарыг оруулаагүй байдаг. Харин тухайн этгээд орлогын мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэртэй нь үл нийцэх хэмжээний “хөрөнгө” буюу “өмч” олж авсан тохиолдолд л үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үздэг. Иймээс, мөрдөгч эдгээр тохиолдолд хөрөнгө олж авахтай холбоотой бүх зардлыг нотлох Эх үүсвэр ба зарцуулалтын бүрэн дүн шинжилгээ хийх шаардлагатай эсэхэд эргэлзэж болно.

Эдгээр хууль тогтоомжийн дагуу мөрдөн шалгах ажиллагааны явцад Эх үүсвэр ба зарцуулалтын бүрэн дүн шинжилгээ (эд хөрөнгөтэй холбоотой бус худалдан авалт, мөнгөн хөрөнгийн ашиглалтыг оруулан) хийх ёстой байдаг. Эдгээр хуулийн дагуу “хөрөнгө” олж авахад төлсөн нийт дүнг л үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нийт зардалд тооцож болох байсан ч тухайн этгээд хууль ёсны дагуу олсон орлогынхоо тодорхой хэсгийг эд хөрөнгөтэй холбоогүй зардалд зарцуулсан болохыг нотлох баримт прокурорын үүсгэсэн хэрэгт тустай байх болно. Учир нь, энэ нь сэжигтний холбогдох эд хөрөнгө худалдан авахад ашиглаж болох орлогын нийт хэмжээ нь тухайн хугацааны нийт хууль ёсны орлогоос бага байсныг нотлох юм.

Тухайлбал, хэрэв тухайн этгээд 10 жилийн хугацаанд хууль ёсны дагуу 500,000 ам.долларын орлоготой байсан бөгөөд энэ хугацаанд 250,000 ам.доллороор хоёр байшин худалдаж авсан гэвэл тухайн этгээд энэ хугацаанд хоёр байшингийн зардлыг төлөх хэмжээний орлоготой байсан гэж маргах магадлалтай. Гэвч, хэрэв мөрдөгчид нийт орлогын 400,000 ам.долларыг эдгээр байшинг худалдан авахад зарцуулаагүй, харин амралт, хандив, үнэтэй оройн зоог зэрэг биет бус үйлчилгээнд зарцуулсан гэдгийг нотолж чадвал тухайн этгээд энэ хугацаанд дээрх хоёр байшинг худалдаж авахад хангалттай орлоготой байсан гэж хэлэх боломжгүй болно. Иймд, энэ тохиолдолд Эх үүсвэр ба зарцуулалтын бүрэн дүн шинжилгээ хийх нь прокурорт маш их тустай байх болно. Учир нь энэ нь тухайн этгээд энэ хугацаанд хүлээн авсан хууль ёсны нийт орлого нь эд хөрөнгө худалдаж авахад ашиглах орлогоос нь бага байсан гэдгийг тодорхой нотлох болно.

## 2.5 Тухайн этгээдийн орлого, зарцуулалтыг илтгэх санхүүгийн нотлох баримтын нийтлэг эх сурвалжууд

Хэрэг болгон өвөрмөц онцлогтой боловч мөрдөгчид тухайн этгээдийн нийт орлого, зарцуулалтын талаарх мэдээллийг олж авахдаа анхаарч үзэх ёстой хэд хэдэн нийтлэг нотлох эх сурвалжууд байдаг. Тэдгээрийг дараах хэсгүүдэд авч үзэх болно.

### 2.5.1 Хөрөнгө орлогын мэдүүлэг (Asset declarations)

Олон улс оронд төрийн албан хаагчид хөрөнгө орлогын мэдүүлгийн маягтыг хуулийн дагуу бөглөж, мэдүүлэх шаардлагатай байдаг. Эдгээр нь төрийн албан хаагчийн (public official) эзэмшиж буй бүх эд хөрөнгө, тодорхой хугацаанд олсон бүх орлогыг мэдүүлэх үүрэгтэй хууль ёсны баримт бичиг юм. Тиймээс, хэрэв үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаа нь төрийн албан хаагчид хамаарах бол тухайн этгээдийн мэдүүлсэн хөрөнгө орлогын мэдүүлгийг олж авах нь мөрдөн шалгах ажиллагааны хамгийн сайн эхлэлийн цэг байх болно. Учир нь эдгээр маягтуудад ихэвчлэн дараах зүйлс багтсан байдаг. Үүнд:

- Субъектийн дэлгэрэнгүй хувийн мэдээлэл, түүнчлэн эхнэр/нөхөр/хамтран амьдрагч болон хүүхдүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- Эзэмшиж буй аливаа үл хөдлөх хөрөнгө (байр, газар гэх мэт);
- Эзэмшиж буй аливаа үнэ цэнэ бүхий хөдлөх хөрөнгө (автомашин, тоног төхөөрөмж, үнэт эдлэл, урлагийн бүтээл);
- Эзэмшдэг аливаа хувьцаа;
- Хяналтад нь байдаг аливаа банкны данс;
- Эзэмшдэг болон ашиг сонирхолтой аливаа бизнес; болон
- Одоо байгаа өр төлбөр, зээл.

Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт нь мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх маш сайн эхлэх цэг боловч авлига авсан байж болзошгүй төрийн албан тушаалтан өөрийн эзэмшилд байдаг бүх өмч хөрөнгө, ашиг сонирхлыг энэхүү мэдүүлэгт санаатай болон санамсаргүй байдлаар мэдүүлээгүй байх магадлалтай гэдгийг санаж байх нь зүйтэй. Иймд, мөрдөгч орлого, хөрөнгө, зарлагыг хайж эхлэх чиглүүлэгч байдлаар л зөвхөн хөрөнгө орлогын мэдүүлгийг ашиглах нь чухал юм.

Тухайлбал, хэрэв тухайн этгээд нь тодорхой байгууллагад банкны данстай гэдгээ мэдүүлсэн бол мөрдөгч тухайн байгууллагаас банкны хуулга авахыг

оролдох ёстой. Түүнчлэн, мөрдөгч тухайн этгээд хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгаагүй данс нээлгэсэн, эсхүл эхнэр, нөхөр, хүүхдүүддээ нэмэлт данс нээлгэсэн, зээл авсан гэх мэт санхүүгийн бусад үйл ажиллагаанд уг банкиг ашигласан эсэхийг шалгах ёстой.

Түүнчлэн, хөрөнгө орлогын мэдүүлэг нь тухайн этгээд өөрийн орлоготой дүйцэхгүй их хэмжээний хөрөнгө олж авсан хугацааг тодорхойлж болно.

Хэрэв, уг этгээд хэдэн жилийн туршид хэд хэдэн удаа хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан бол мөрдөгч тухайн этгээд их хэмжээний хөрөнгө олж авсан хугацааг тодорхойлох үүднээс мэдүүлгүүдийг хооронд нь харьцуулах ёстой. Энэ нь тухайн этгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үед хамаарах анхаарвал зохих хугацааг тогтооход тус дөхөм болж болно.

## 2.5.2 Татварын буцаалтын тайлан (Tax return forms)

Тухайн этгээдийн татварын буцаалтын тайлан нь мөрдөн шалгах үйл ажиллагаанд туслах санхүүгийн асар их мэдээллийг агуулдаг. Эдгээр тайлан нь ихэвчлэн дараахтай холбоотой чухал мэдээллийг агуулдаг. Үүнд:

- Тухайн этгээдийн тухайн татварын жилд хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалт, тээврийн хэрэгсэл болон албан татвар ногдуулах бусад эх үүсвэрээс олж авсан нийт мэдүүлсэн орлого;
- Тухайн этгээдийн эзэмшиж буй банкны данс, тэдгээрийн үлдэгдэл;
- Тухайн этгээдийн эзэмшиж буй аливаа үл хөдлөх эд хөрөнгө болон бусад ач холбогдол бүхий хөрөнгө.

Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй нэгэн адил татварын тайлан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эхлэлийн цэг юм. Гэхдээ мөрдөгч нь тухайн этгээд татварын тайландаа холбогдох бүх орлого, хөрөнгөө мэдүүлсэн гэж үзэж болохгүй бөгөөд тухайн этгээдийн нийт хөрөнгө, санхүүгийн дансыг нэмэлт арга замаар нотлохыг оролдох ёстой.

## 2.5.3 Ажилласан байдал

Төрийн байгууллага ч бай, хувийн компани ч бай тухайн этгээдийн ажлын байр нь тухайн этгээд ажиллаж байх хугацаанд нь төлсөн нийт орлогын дүнтэй холбоотой бүртгэлтэй байдаг<sup>11</sup>. Энэхүү мэдээллийг татварын тайлангаар баталгаажуулах боломжтой бөгөөд энэ нь Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг үнэн зөв хийх чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

11 Хэрвээ үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуульд тухайн этгээдийг төрийн албан хаагч гэдгийг нотлох шаардлагатай байвал энэхүү мэдээлэл нь мөн хуулийн тэр хэсгийг тогтооход нэмэр болно.

## 2.5.4 Банк болон санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллага (мобайл мөнгөний данс гэх мэт)

Тухайн этгээдийн банкны данс нь санхүүгийн мэдээллийн маш үнэ цэнтэй эх сурвалж байдаг. Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний хүрээнд хувь хүний банкны дансны мэдээлэл нь дараах зүйлийг тодорхойлж, тогтооход чухал ач холбогдолтой байх юм:

### → Хууль ёсны орлого, тухайлбал:

- Анхаарвал зохих хугацааны эхний өдөр тухайн этгээдийн дансны үлдэгдэлд байгаа хөрөнгийн нийт дүнгээр илэрхийлэгдсэн анхаарвал зохих хугацаанаас өмнөх орлого болох тухайн этгээдийн хадгалсан, хуримтлуулсан нийт хөрөнгийн дүн;
- Хууль ёсны эх үүсвэрээс (жишээ нь, ажлын цалин хөлс, хөрөнгө оруулалтаас орсон ногдол ашиг/хүү гэх мэт) олсон байж болох аливаа мөнгөн хөрөнгийн хэмжээ;
- Тухайн этгээдийн хүлээн авсан байж болох аливаа зээлийн хэмжээ.

### → Тухайн этгээдэд хамаарах зарцуулалт, тухайлбал:

- Анхаарвал зохих хугацааны сүүлийн өдөр тухайн этгээдийн дансны үлдэгдэлд байгаа мөнгөн хөрөнгийн нийт дүнгээр илэрхийлэгдсэн анхаарвал зохих хугацааны үеийн орлого болох түүний хадгалсан, хуримтлуулсан хөрөнгийн нийт мөнгөн дүн;
- Тухайн этгээдийн хөрөнгө, үйлчилгээ болон бусад зүйлийг худалдан авах зорилгоор гуравдагч этгээдэд шилжүүлсэн/дамжуулсан шилжүүлсэн мөнгөн дүн;
- Тухайн этгээдийн бусад талуудад бэлэг болгон шилжүүлсэн байж болох мөнгөн дүн;
- Тухайн этгээдийн зээлийн эргэн төлөлтөд төлсөн мөнгөн дүн.

Түүнчлэн, нэг дансны банкны хуулганд тухайн этгээдийн хяналтад байдаг бусад данс руу эсхүл тэдгээр данснаас хийсэн нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай мөнгөн шилжүүлэг, тэр дундаа уламжлалт банкны данстай холбоотой зээлийн картын дансыг шалгана.

Дэлхий даяар аливаа этгээдийн гар утасны SIM карттай холбоотой мобайл мөнгөний дансны хэрэглээ улам өргөжиж байгаатай холбоотой тэдгээрийг уламжлалт банкны данстай адил авч үзэх ёстой. Эдгээр данс нь ихэвчлэн шилжүүлэг хийх хязгаарлалттай байдаг ч урт удаан хугацааны туршид шалгахад тухайн этгээд уг хугацаанд хийсэн нийт зардлын ихээхэн хэсгийг ил болгож болно.

Ерөнхийдөө, банкны данс болон мобайл мөнгөний дансууд нь санхүүгийн мэдээллийн маш чухал эх сурвалж болдог. Учир нь эдгээр нь:



- Сэжигтэнтэй холбоотой мөнгөн гүйлгээний ерөнхий тойм, мөн орж ирсэн төлбөр, зарлагын дадал зуршлын бүртгэл болдог;
- Уг данстай холбоотой бусад мобайл мөнгөний данс, бизнес, байшин, автомашин гэх мэт бусад хөрөнгийг шууд болон шууд бусаар тодорхойлоход ашиглагдах;
- Мөрдөгчид нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай байж болох сэжигтэй гүйлгээг (жишээ нь, авлига авсан байж болох) олж тогтоох боломжийг олгодог.

Дансны гүйлгээний мэдээлэл нь тухайн этгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болох анхаарвал зохих хугацааны талаар мөрдөгчийг чиглүүлж болох их хэмжээний мөнгө хүлээн авсан эсхүл дансандаа байршуулсан хугацааг мөн зааж өгч болно. Түүнчлэн, дансны мэдээлэл нь тухайн этгээд их хэмжээний бэлэн мөнгийг гаргаж авсан огноог зааж өгч болно. Энэ нь уг этгээд тухайн хөрөнгийг худалдаж авсан гэдгийг нуун дарагдуулахын тулд тухайн өдөр эсхүл ойролцоо хугацаанд тодорхой нэг хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдаж авсан гэх нэхэмжлэлийг батлах нотолгоо болж болох юм.

### **2.5.5 Эд хөрөнгийн улсын бүртгэл (Government asset registries)**

Хөрөнгийн өмчлөлийн талаарх төрийн мэдээллийн бүртгэл нь үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл зэрэг томоохон хөрөнгө худалдаж авах, эзэмшихтэй холбоотой чухал нотлох баримтуудыг өгч болно. Мэдээжийн хэрэг, олон оронд үл хөдлөх хөрөнгийн ихээхэн хувийг өмчлөлийн талаар төрийн мэдээллийн санд бүртгэдэггүй бөгөөд энэ нь мөрдөгчдөд тухайн этгээдийн эзэмшиж болох эд хөрөнгийн бүх мэдээллийг олж илрүүлэхэд хүндрэл учруулдаг.

Жич, иймэрхүү үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг бусад уламжлалт арга хэрэгслээр, тухайлбал банк эсхүл мобайл мөнгөний данснаас үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой төлбөрийг тогтоох болон ажиглалт тандалт хийх замаар тодорхойлж болно.

### **2.5.6 Хуулийн этгээдийн улсын бүртгэл (Corporate registries)**

Тухайн улсад байгаа компаниудын эздийн талаарх мэдээллийг ихэвчлэн мэдээллийн нэгдсэн санд бүртгэдэг. Дээр дурдсан үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгслийн бүртгэлийн нэгэн адил эдгээр мэдээллийн сан нь тухайн этгээдийн бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эзэмшдэг хувийн компанийн тоо зэрэг Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээнд холбогдох мэдээллийг өгөх боломжтой. Хайлтын үр дүнд тухайн этгээд тодорхой хувийн компанийг

бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эзэмшдэг болох нь тогтоогдвол тэдгээр компанийн санхүүгийн мэдээллийг (мөн тус компанид орж ирж байгаа болон гарч буй хөрөнгийн урсгалын эх үүсвэр, тэдгээрийн очих газарт анхаарах) мөн шалгах ёстой. Учир нь, гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон мөнгийг хүлээн авсан, ашигласнаа нуун далдлах зорилгоор хуулийн этгээдийг түлхүү ашигладаг.

### **2.5.7 Хөрөнгийн биржийн бүртгэл (Stock exchange registries)**

Хөрөнгийн биржийн бүртгэл нь мөн хувьцаа болон бусад үнэт цаас худалдаж авсан талаарх мэдээллийг мөрдөгчид өгч болно. Ихэнхдээ иймэрхүү хөрөнгийн биржийн мэдээлэл нь тухайн этгээд хувьцаа худалдаж авахдаа мэргэжлийн брокер ашигласан эсхийг харуулдаг. Хэрэв тийм бол тухайн этгээдэд үйлчилгээний шимтгэлд төлсөн мөнгөн дүнгийн талаарх мэдээллээр тогтохгүй тухайн этгээдийн нэрийн өмнөөс хийсэн бусад хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг нотлох эх сурвалж нь брокер болж болзошгүй юм.

### **2.5.8 Барилга байгууламжид нэгжлэг хийх**

Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй этгээдтэй холбоотой барилга байгууламжид газар дээр нь нэгжлэг хийхэд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд тус дөхөм болохуйц олон чухал мэдээлэл, нотлох баримтыг олж илрүүлж болно. Нэгжлэг нь мөрдөгчид тухайн этгээдийн олж авсан ач холбогдол бүхий хөрөнгө, тэр дундаа их хэмжээний бэлэн мөнгө зэргийг олж илрүүлэх, хураан авахад тусалж болно. Мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулах шаардлагагүй болсон, мөн мөрдөгчид нэгжлэг хийх хууль ёсны эрх мэдэлтэй болохуйц хангалттай мэдээлэл, нотлох баримтыг цуглуулсан тохиолдолд иймэрхүү нэгжлэг нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой бүх мөрдөн шалгах ажиллагааны нэг хэсэг байх ёстой.

Мөрдөгчид нэгжлэг хийх явцад холбогдох үнэ бүхий эд зүйлс, хөрөнгийг илрүүлж, хураахаас гадна аливаа хөрөнгөд тухайн этгээдийн болон бусад холбогдох этгээдийн (эхнэр, нөхөр гэх мэт) “ашиг сонирхлыг” илтгэсэн буюу нотолсон бүхий л төрлийн зүйлийг олж илрүүлэх, хураан авахад анхаарах ёстой. Тухайлбал, мөрдөгч нэгжлэг хийх явцад шалгагдаж байгаа этгээдийн нэр дээр үл мэдэгдэх тээврийн хэрэгслийн даатгалын баримт бичгийг олж илрүүлсэн бол энэ баримт нь зөвхөн тухайн этгээд аль даатгалын компанийн үйлчлүүлэгч болохыг илтгэхээс гадна тухайн этгээд үл мэдэгдэх тээврийн хэрэгсэл эзэмшдэг болохыг нотлох чухал баримт болдог.

Нэгжлэгийн явцад мөрдөгчийн цуглуулах ёстой зүйлд дараах зүйлс орно. Үүнд:

- Банкинд орлого хийсэн баримт;
- Банкны хуулга;
- Чек;
- Зээлийн бичиг баримт, гэрээ;
- Дебит болон зээлийн карт;
- Зээлийн картын хуулга;
- Өмч эзэмших эрхийн гэрчилгээ эсхүл үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бусад баримт бичиг (тухайлбал, архитектурын төлөвлөгөө, хаяг нь бичигдсэн захидал харилцаа гэх мэт);
- Цахилгаан, ус, кабелийн телевизийн төлбөр;
- Бусад төлбөр, худалдан авалтын нэхэмжлэх, төлбөрийн баримт, үүнд:
  - Даатгал;
  - Онгоцны билет;
  - Зочид буудлын төлбөр;
  - Сургалтын төлбөр;
  - Буяны хандив; болон
  - Бусад өдөр тутмын худалдан авалт;
- Эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (тухайлбал байшин, автомашин худалдах эсхүл худалдан авах гэрээ);
- Түрээсийн гэрээ;
- Хөдөлмөрийн гэрээ;
- Тэтгэвэртэй холбоотой баримт бичиг;
- Гэр бүл салалттай холбоотой бичиг баримт;
- Татварын буцаалтын өргөдөл эсхүл татварын төлбөрийн баримт;
- Аж ахуйн нэгжийн бүртгэлийн бичиг баримт болон тухайн этгээд, түүний гэр бүлтэй холбоотой бизнесийн өмчлөл, ажиллуулах эсхүл орлоготой холбоотой бусад баримт бичиг;
- Тээврийн хэрэгсэлтэй холбоотой өмчлөлийн бичиг баримт;
- Хөрөнгийн өмчлөлийн болон төлбөрийн талаарх захидал харилцаа, гараар бичсэн тэмдэглэл, өдрийн тэмдэглэл;
- Паспорт;
- Клубийн гишүүнчлэлийн карт (жишээ нь, клубийн гишүүнчлэлийн

карт эсхүл нисэх онгоцны байнгын нислэгийн карттай холбоотой);

- Криптовалютын данстай холбоотой байж болох баримт бичиг;
- Цахим мэдээлэл агуулсан аливаа эд зүйл (Хүснэгт 2-ыг үзнэ үү); болон
- Аливаа төрлийн эд хөрөнгөд ашиг сонирхолтойг илтгэх бусад зүйлс.

### **Хүснэгт №2: Нэгжлэгийн явцад цуглуулах цахим мэдээлэл**

Нэгжлэг хийх явцад цахим мэдээлэл агуулсан эд зүйлсийг олох магадлалтай. Үүнд дараах цахим эд зүйлс байж болно:

- Компьютер эсхүл зөөврийн компьютер
- Таблет төхөөрөмж
- Гар утас
- Зөөврийн хард диск
- USB диск
- CD-нүүд

Эдгээр зүйлсийг мөн нэгжлэгийн явцад цуглуулж, шүүхийн шинжилгээний шинжээчдээр шинжлүүлэх нь чухал юм. Эдгээр зүйл нь гэмт хэргийн нотлох баримт эсхүл уг этгээдийн тухайн хөрөнгө дэх ашиг сонирхлыг тусгайлан илтгэсэн цахим шуудан, баримт бичиг, хүснэгт, PDF файл зэрэг мөрдөн шалгах ажиллагаанд асар их ач холбогдолтой мэдээллийг агуулж болно. Тухайлбал, тухайн этгээдэд ирсэн цахим шууданд тухайн этгээдийн хийсэн эсхүл хүлээн авсан төлбөрийн талаарх мэдээлэл эсхүл тухайн этгээдийн данс, ажиллуулдаг бизнесийн талаарх мэдээлэл, тэр байтугай гадаад дахь ашиг сонирхолтой нь холбоотой мэдээллийг агуулж болно. Түүнчлэн, компьютер дэх программууд эсхүл өмнө нь үзсэн цахим хуудасны талаарх өгөгдөл нь тухайн этгээдийн банкны үйлчилгээ авахдаа ашигладаг санхүүгийн байгууллагуудыг илтгэх эсхүл худалдан авалт хийхдээ ашигладаг цахим хуудас (жишээ нь, Amazon, Booking.com гэх мэт) эсхүл ашигладаг аливаа цахим төлбөр/мөнгө шилжүүлэх үйлчилгээ зэрэг санхүүгийн нотлох баримтын нэмэлт эх сурвалжуудыг агуулж болно (жишээ нь PayPal эсхүл Wise).

Энэ бүх мэдээлэл нь гэмт хэргийг илрүүлэх, тухайн этгээдийн эзэмшдэг хөрөнгө, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг илрүүлж тогтооход ихээхэн ач холбогдолтой.

Хэрэв, ийм эд зүйл хураагдсан бол мөрдөгч зайлшгүй шаардлагатай л биш бол (жишээ нь төхөөрөмж блоклогдохоос сэргийлж) тухайн зүйлээр оролдохгүй байх нь чухал юм. Тоног төхөөрөмжтэй харьцах аливаа харилцааг компьютерын мэргэшсэн шинжээч нарт даатгах ёстой.

## 2.5.9 Хуулиар тогтоосон эд хөрөнгийг ил мэдээлэх тухай эрх зүйн зохицуулалт

Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай олон хууль тогтоомжид мөрдөн шалгагдаж байгаа этгээдээс эзэмшдэг эд хөрөнгө, олсон орлогынхоо талаарх мэдээллийг гаргаж өгөхийг албан ёсоор шаардах эрхийг хууль сахиулах байгууллагад олгодог.

Хэрэв, хуульд ийм бүрэн эрхийг олгосон бол тухайн этгээд мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад мэдээлэл өгөх боломжтой байж магадгүй тул мөрдөгч ийм хүсэлт гаргах талаар бодож үзэх хэрэгтэй. Хэдийгээр, хуулиар хүлээсэн эрх үүргийн хүрээнд тухайн этгээд хамтран ажиллахгүй байх бүрэн боломжтой ч зарим сэжигтний хүсэлтийг урьд өмнө нь мэдэгдээгүй байсан өөрийн эзэмшиж байсан хөрөнгө, мөн татварын мэдүүлэг эсхүл бусад эд хөрөнгийн ил тод байдлын мэдүүлэгт тусгаагүй байсныг хууль ёсоор олсон орлогыг мэдүүлэх боломж болгон ашиглаж болно.

### 2.5.10 Сэжигтнээс мэдүүлэг авах

Мөрдөгчид уламжлалт мэдүүлэг, байцаалтыг тухайн этгээдийн орлого, хөрөнгө, зардлын талаар мэдээлэл олж авах арга хэрэгсэл болгон ашиглаж болно. Хэдийгээр, мөрдөн шалгагдаж буй хүмүүсийн ихэнх нь иймэрхүү байцаалтад хамтран ажиллахгүй байж болох ч зарим нь эдгээр байцаалтыг мөрдөгчдөөс өөрсдөд нь тавьсан аливаа үл нийцэх зарцуулалтыг тайлбарлах боломж болгон ашиглаж болно. Мөрдөн шалгах ажиллагааны үүднээс авч үзвэл, мөрдөгчид анхаарвал зохих хугацаанд тухайн этгээдийн олж авсан хууль ёсны бүх орлогыг тогтоож баталгаажуулах арга хэрэгсэл болгон байцаалтыг ашиглах нь гарцаагүй. Учир нь, энэ нь тухайн этгээд шүүх хуралдааны үеэр хэргийн үр дүнд нөлөөлж болох ямар нэгэн гэнэтийн “тайлбар” гаргахгүй байх баталгааг өгөх юм. Тухайлбал, байцаалт нь сэжигтнээс аль нэг хугацаанд их хэмжээний бэлэн мөнгөтэй байсан эсэхийг асуух таатай боломж юм (мөн үүнийгээ нотлох), үгүй бол энэ нь шүүх дээр гарч ирж болзошгүй юм<sup>12</sup>.

12 Хүмүүс ихэвчлэн өөрсдийн үл нийцэх зардлаа тайлбарлахдаа ашигладаг нийтлэг “тайлбар” нь анхаарвал зохих хугацаанаас өмнө олсон орлого эсхүл анхаарвал зохих хугацааны үеэр олсон орлогоосоо хуримтлуулсан бэлэн мөнгөөр (хэдийгээр уг бэлэн мөнгийг өмнө нь мэдүүлээгүй байсан ч гэсэн) худалдан авалт хийсэн гэж мэдүүлдэг. Прокурор Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхдээ анхааралдаа аваагүй байсан их хэмжээний бэлэн мөнгөтэй байсан гэж худал мэдүүлж, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнөө амжилттай “тайлбарлах” магадлалыг бууруулахад шүүхээс өмнө хийх байцаалт маш чухал байдаг. Байцаалтын үеийн асуултууд, тухайлбал, “Та [огноог оруулах]-ны байдлаар хэр их хэмжээний бэлэн мөнгөтэй байсан бэ” эсхүл “Сүүлийн 5 жилийн хугацаанд танд байсан хамгийн их хэмжээний бэлэн мөнгө хэд байсан бэ” гэх мэт асуулт тавибал тухайн этгээдийг хожим нь байцаалтын үеэр хэлсэн мөнгөнөөс их хэмжээний бэлэн мөнгөтэй байсан гэж мэдэгдэхэд хүнд байдалд оруулах болно. Учир нь энэ нь өөрийнх нь нотлох баримттай шууд зөрчилдөх болно.

Мөрдөгч нь мөн мөрдөн шалгагдаж байгаа этгээдийн амьдралын хэв маягийн талаар илүү нарийвчилсан дүр зургийг гаргаж авахын тулд түүний ойр дотны хүмүүсээс мэдүүлэг авах нь зүйтэй юм. Учир нь, энэ нь мөрдөгчид өмнө нь мэдэгдээгүй нэмэлт зарцуулалтыг олж илрүүлэхэд хүргэж болно.

Мэдүүлэг авах хугацааг, ялангуяа мөрдөн шалгах ажиллагаа далд шатандаа явж байгаа үед сайтар бодож үзэх хэрэгтэй. Мөрдөгч эхний мэдүүлгээр сэжигтний өгсөн тайлбар дараа нь няцаагдсан тохиолдолд дараагийн байцаалтыг хийх талаар бодож үзэх ёстой.

### **2.5.11 Тандалт ажиглалт хийх (Surveillance)**

Тандалт хийх зэрэг уламжлалт мөрдөн шалгах ажиллагааны арга техник нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд маш их хэрэгтэй байдаг.

Тухайлбал, тандалт хийх явцад тухайн этгээдийн эзэмшдэг боловч өөр өөр хувь этгээд, байгууллагын нэр дээр бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгө, автомашин болон санхүүгийн үйл ажиллагаа явуулахад нь ашигладаг санхүүгийн байгууллага, тэр байтугай өдөр тутам мөнгө зарцуулдаг дэлгүүр, рестораны нэр төрлийг илрүүлэх боломжтой байдаг.

### **2.5.12 Олон улсын мэдээллийн эх сурвалж**

Тухайн этгээдийн орлого, эд хөрөнгөтэй холбоотой нотлох баримтууд гадны улс оронд байж болно. Тухайлбал, мөрдөн шалгагдаж буй этгээд нь өөрийн очих дуртай гадаад оронд томоохон өмч худалдаж авсан эсхүл тухайн улсын хууль эрх зүйн тогтолцоо нь өөрийнх нь оршин суудаг улсын эрх баригчдаас эзэмшигчийн мэдээллийг нуун дарагдуулахад нь тусалсан байж болно.

Мөрдөгчид боломжтой бол эдгээр мэдээллийг олж авахыг эрэлхийлэх хэрэгтэй, гэхдээ бусад улсын хууль сахиулах байгууллагууд тухайн улсад үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай эсэхээс үл хамааран хамтран ажиллах саналыг хүлээж авах эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй.

# З

Эх үүсвэр болон  
зарцуулалтын дүн  
шинжилгээ хийж  
үндэслэлгүйгээр  
хөрөнгөжсөн  
ЭСЭХИЙГ ТОГТООХ НЬ

### 3.1 Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийх нь (тохиолдлын жишээн дээр)

Энэ хэсэгт Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь практикт хэрхэн хэрэгжиж болох жишээг хялбаршуулсан хэргийн жишээгээр харуулах болно:

2020 оны 9 дүгээр сард Авлигатай тэмцэх цагдаагийн албанд импортын татварын үнэлгээний ажилтан Ноён Смит авлига авч, анхан шатны төрийн албан хаагчийн цалингийн хэмжээтэй дүйцэхгүй амьжиргааны түвшингээр амьдарч байна гэсэн нэрээ нууцалсан мэдээлэл иржээ.

Урьдчилсан мөрдөн шалгалтын дараа, мөрдөгч авлигын хэргийг нотлох баримтыг олж чадаагүй ч Ноён Смит нь төрийн албан хаагч болсноос хойш найман сарын хугацаанд түүний цалинтай дүйцэхгүй гэж харагдахаар хэмжээний эд хөрөнгөтэй болсныг тогтоож чадсан байна. Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнийг тогтоох мөрдөн шалгах ажиллагаа явуулах даалгаврыг мөрдөгч авчээ.

Өмнөх хэсэгт тайлбарласны дагуу үндэслэлгүй хөрөнгөжсөн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхийн тулд мөрдөгч Ноён Смитийн бүх орлого, зарцуулалтын талаар нотлох баримт цуглуулахын тулд санхүүгийн нарийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах ёстой. Мөрдөгч өмнөх хэсэгт дурдсан санхүүгийн нотлох баримтын бүх нийтлэг эх сурвалжийг судалж, тухайн хэрэгт онцлог байж болох мөрдөн шалгах ажиллагааны бусад арга замыг сонгох замаар энэ тохиолдлын жишээн дээр ажиллах болно.

Мөрдөгч санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа дараах баримтуудыг олж тогтооно:

- Ноён Смит нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс төрийн албан хаагчаар ажиллаж эхэлсэн бөгөөд сар бүр 3,000 ам.долларын цалин авдаг байсан;
- 2020 оноос өмнө Ноён Смит их сургуульд сурч байсан, тодорхой эрхэлсэн ажилгүй, эцэг эхийнхээ гэрт амьдардаг байсан;



- Ноён Смит 2020 оны 1 дүгээр сарын 1-нд XYZ банканд нээлгэсэн ганцхан банкны данс эзэмшиж байсан (Дансны дугаар 1234-4321). Тэрбээр энэ дансанд цалингаа сар бүр авдаг байсан;
- Ноён Смит уг банкны данснаасаа гадна Mobile Money Limited компанид 2020 оны 1 дүгээр сарын 3-нд нээсэн мобайл мөнгөний данстай (дансны дугаар 98-765-6789). Тэрбээр энэхүү мобайл дансыг ашиглан өдөр тутмын гүйлгээ худалдан авалт (хоол хүнс, төлбөр тооцоо төлөх гэх мэт)-ын дийлэнх хувийг хийдэг;
- 2020 онд Ноён Смит өдөр тутмын зардлаасаа гадна автомашин (8,000 ам.доллар), газар (30,000 ам.доллар) худалдаж авахаас гадна уг газарт байшин барих барилгын ажлыг эхлүүлэхийн тулд гүйцэтгэгчид албан бусаар төлбөр (3,000 ам.доллар) төлсөн – эдгээрийг бүгдийг нь бэлнээр хийсэн;
- Ноён Смитын дансанд одоогоор 27,000 ам.доллар байгаа.

Мэдүүлэг авах үеэр Ноён Смит түүний ээж 1 дүгээр сарын зардалд зориулж оны эхээр 1,000 ам.доллар бэлнээр өгсөн гэж мэдүүлсэн (энэ нь батлагдсан). Тэрбээр бусад эх үүсвэрээс мөнгө авсан гэж мэдүүлээгүй.

Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг хялбарчлахын тулд мөрдөгч өөрийн олсон баримтыг Microsoft Excel зэрэг компьютерын программд оруулж, **Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтийг** үүсгэх хэрэгтэй. Энэхүү хүснэгт нь мөрдөн шалгах ажиллагааны явцад хийгдсэн байх ёстой бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны явцад орлого, зарцуулалтын шинэ зүйл бүрийг нотлох баримтаар тогтоогдоход байнга шинэчлэгдэж байдаг баримт бичиг байх ёстой.

Үндсэндээ, Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтэд дараах зүйлийг он цагийн дарааллаар жагсаах ёстой. Үүнд:

- Зорилтот этгээд (болон эхнэр, нөхөр гэх мэт бусад холбогдох хүмүүс) мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс орж ирсэн мөнгөн хөрөнгийг хүлээн авсан тохиолдол бүр;
- Зорилтот этгээд (болон эхнэр, нөхөр гэх мэт бусад холбогдох хүмүүс) мөнгөн хөрөнгийг ашигласан тохиолдол бүр;
- Сонгосон хугацааны эхэнд тухайн этгээдийн (мөн эхнэр, нөхөр гэх мэт бусад холбогдох этгээдийн) эзэмшиж байсан банк эсхүл мобайл мөнгөний дансны үлдэгдэл;

- Сонгосон хугацааны эцэст тухайн этгээдийн (мөн эхнэр, нөхөр гэх мэт бусад холбогдох этгээдийн) эзэмшиж буй банк эсхүл мобайл мөнгөний дансны үлдэгдэл.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад олон зуун, тэр ч байтугай хэдэн мянган гүйлгээтэй холбоотой нотлох баримтыг цуглуулдаг. Ийм тохиолдолд, зарим гүйлгээг тодорхой болгох үүднээс нэг зүйлийн дор нэгтгэж болно. Тухайлбал, хэрэв тухайн этгээд мобайл мөнгөний данс эсхүл зээлийн карт ашиглан өдөр тутмын худалдан авалт хийхдээ олон арван жижиг гүйлгээ хийдэг бол мөрдөгч эдгээр гүйлгээг долоо хоног эсхүл сарын нийлбэр дүнгээр нэгтгэж, хүснэгтийг хялбарчлах боломжтой. Эдгээр өдөр тутмын гүйлгээ бүрийн бодит жагсаалтыг шаардлагатай бол нэмэлт лавлагааны зорилгоор тусдаа Microsoft Excel хуудсанд байрлуулж болно.

Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтийг анх үүсгэх үед анхаарвал зохих хугацаа хараахан тодорхой болоогүй байж болно. Энэ тохиолдолд мөрдөгч эхлээд нотлох баримтаар нотлох боломжтой ямар ч хугацаанд хамаарах бүх орлого, зарцуулалтыг хүснэгтэд оруулах хэрэгтэй. Анхаарвал зохих хугацааг сонгосны дараа хүснэгтийг зөвхөн сонгосон хугацаанд хамаарах мэдээллийг оруулахаар өөрчилж болно (доорх 3.2-р хэсгийг үзнэ үү).

Хэрэв, хүснэгтийг зөвхөн тодорхой нэг хугацааны гүйлгээг оруулахаар өөрчилсөн бол мөрдөгч нотлох боломжтой тухайн этгээдийн сонгосон хугацааны эхний өдрөөс өмнө олсон орлогоос хуримтлуулах боломжтой байсан хадгаламжийн нийт дүнг оруулахад анхаарах ёстой. Энэ нь анхаарвал зохих хугацааны эхний өдрийн 12:00 цагийн байдлаар тухайн этгээдийн өөрийн банк болон мобайл мөнгөний дансанд хадгалсан мөнгөн хөрөнгийн нийт дүн, мөн тухайн үед уг этгээдийн хяналтад байсан нотлох боломжтой бэлэн мөнгөний дүнгээр илэрхийлэгдэнэ.

Тухайлбал, Эх үүсвэр ба зарцуулалтын эцэслэсэн хүснэгт нь дараах хэлбэртэй байна (хялбар болгох үүднээс анхаарвал зохих хугацаагаар Ноён Смит төрийн албанд байсан бүх хугацааг сонгосон болно):

## Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгт Ноён Жон Смит

Анхаарвал зохих хугацаа: 2020.01.01-2020.08.31

ОРЛОГО			ЗАРЦУУЛАЛТ		
Тайлбар	Огноо	Дүн	Тайлбар	Огноо	Дүн
XYZ банк дахь дансны 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл (өмнөх орлогын хуримтлал)	1 дүгээр сарын 1 2020	0	2020 оны 1 дүгээр сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	1 дүгээр сарын 31 2020	900
2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн эхэнд Мобайл мөнгөний дансанд байсан үлдэгдэл (өмнөх орлогын хуримтлал)	1 дүгээр сарын 1 2020	0	2020 оны 2 дугаар сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	2 дугаар сарын 29 2020	1600
Эхээс нь өгсөн бэлэг (бэлэн мөнгө)	1 дүгээр сарын 5 2020	1000	2020 оны 3 дугаар сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	3 дугаар сарын 31 2020	1100
2020 оны 1 дүгээр сарын цалин	1 дүгээр сарын 20 2020	3000	2020 оны 4 дүгээр сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	4 дүгээр сарын 30 2020	1600
2020 оны 2 дугаар сарын цалин	2 дугаар сарын 20 2020	3000	Автомашин худалдаж авсан (бэлнээр төлсөн)	5 дугаар сарын 4 2020	8000
2020 оны 3 дугаар сарын цалин	3 дугаар сарын 20 2020	3000	2020 оны 5 дугаар сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	5 дугаар сарын 31 2020	1200
2020 оны 4 дүгээр сарын цалин	4 дүгээр сарын 20 2020	3000	Газрын төлбөр	6 дугаар сарын 2 2020	30000
2020 оны 5 дугаар сарын цалин	5 дугаар сарын 20 2020	3000	2020 оны 6 дугаар сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	6 дугаар сарын 30 2020	600
2020 оны 6 дугаар сарын цалин	6 дугаар сарын 20 2020	3000	2020 оны 1 дүгээр сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ 2020 оны 7 дугаар сар	7 дугаар сарын 31 2020	700
2020 оны 7 дугаар сарын цалин	7 дугаар сарын 20 2020	3000	Байшингийн барилгын ажлын урьдчилгаанд гүйцэтгэгчид бэлнээр төлсөн төлбөр	8 дугаар сарын 31 2020	3000
2020 оны 8 дугаар сарын цалин	8 дугаар сарын 20 2020	3000	2020 оны 8 дугаар сард Мобайл мөнгөний данснаас гарсан нийт гүйлгээ	8 дугаар сарын 31 2020	1100
<b>Мэгэгдэж буй/хууль ёсны эх үүсвэрээс орсон нийт орлого</b>		<b>25000</b>	XYZ банк дахь дансны 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	8 дугаар сарын 31 2020	27000
			Мобайл мөнгөний дансны 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн төгсгөл дэх үлдэгдэл	8 дугаар сарын 31 2020	200
			<b>2020.01.01-2020.08.31 хоорондох нийт зарцуулалт</b>		<b>77000</b>
			<b>2020.01.01-2020.08.31 хооронд мэдэгдэж буй хууль ёсны эх үүсвэрээс орсон нийт орлого</b>		<b>- 25000</b>
			<b>Үл мэдэгдэх/хууль бус эх үүсвэрээс орсон мөнгөн хөрөнгө</b>		<b>52000</b>

Дээрх хүснэгтээс харахад энэ хэргийн мөрдөгч Ноён Смитийн мобайл мөнгөний данснаас сар бүр төлсөн төлбөрийн нийлбэрийг тус тусад нь тооцож, үүнийг сар бүр нэг бичилт болгон оруулсан байна. Энэ нь бүх тохиолдолд шаардлагагүй боловч Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтийг илүү товч бөгөөд уншихад хялбар болгоно.

Энд авч үзсэн хэргийн жишээ болон түүний үр дүнд гарсан Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгт нь бодит амьдрал дээрх хэргийн хялбаршуулсан хувилбар гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Практикт санхүүгийн нарийн хяналт шалгалтаар тухайн этгээд олон банканд данс эзэмшиж, олон мянган гүйлгээ хийсэн болох нь тогтоогдож болно. Түүнчлэн, тухайн этгээд ихэвчлэн зээл, хөрөнгө оруулалт эсхүл нэмэлт бизнес гэх мэт илүү нарийн төвөгтэй эх үүсвэрээс орлого олох боломжтой. Ийм тохиолдолд Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтийн үнэн зөв эсэх нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж чадах нотлох баримтын хэмжээнээс ихээхэн хамаардаг гэдгийг санах нь чухал юм. Үндсэндээ, Эх үүсвэр ба зарцуулалтын хүснэгтэд аль болох олон нотлох баримтыг цуглуулж, оруулах тусам тухайн хэргийн нотолгоо илүү хүчтэй байх болно.

## 3.2 Анхаарвал зохих хугацааг сонгох нь (Selecting period of interest)

Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний суурь зүйл нь дүн шинжилгээ нь өөрөө **тодорхой тогтоосон хугацаанд** хүлээн авч ашигласан мөнгөн хөрөнгийн орлого, зарцуулалттай холбоотой байх ёстой бөгөөд үүнийг ихэвчлэн “анхаарвал зохих хугацаа” эсхүл “хяналт шалгалтын хугацаа” гэж нэрлэдэг.

Дэлхий дахинаа шүүхэд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг шийдвэрлэхдээ анхаарвал зохих хугацааг ашиглах нь түгээмэл байдаг. Тухайн этгээд тодорхой хугацааны туршид амьжиргааны түвшингээ хадгалах эсхүл өмч олж авахын тулд хууль бус хөрөнгө чинээ ашигласан эсэхийг тогтоохын тулд шүүх ихэвчлэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эсэхэд дүгнэлт хийх тодорхой хугацааг тогтоодог. Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь энэхүү шүүхийн арга барилыг тусгасан байдаг.

Дараах зүйлд Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийх анхаарвал зохих хугацааг тогтоохдоо анхаарах ёстой асуудлыг тусгав. Мөрдөгч/прокурорын сонгосон анхаарвал зохих хугацааг өмгөөллийн тал эсэргүүцэж болзошгүй тул шүүх хуралдааны явцад анхаарвал зохих хугацааг тогтоох шийдвэрийг үндэслэлтэй нотлох, тайлбарлах боломжтой байх ёстой гэдгийг анхаарах хэрэгтэй.

### 3.2.1 Анхаарвал зохих хугацааг тогтооход хуульд заасан хязгаарлалт байдаг уу?

Үндсэн гарын авлагын 3.3.2-т тайлбарласнаар, шүүхийн хэд хэдэн шийдвэрт үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэдгийг шүүхээс тогтооход ашигласан анхаарвал зохих хугацаа нь хэн нэгнийг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй байх бүх цаг хугацаатай нийцэх албагүй гэдгийг тодорхой заасан байдаг. Тухайлбал, зөвхөн төрийн албан хаагчдад үйлчилдэг хууль тогтоомжийн хувьд хэн нэгний төрийн албан хаагч байсан нийт хугацаа эсхүл хууль тогтоомжид заасан хөөн хэлэлцэх хугацаатай нийцэх шаардлагагүй. Харин анхаарвал зохих хугацаа гэдэг нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэх (тухайлбал, төрийн албан хаагч тайлбарлах боломжгүй байдлаар их хэмжээний хөрөнгө олж авсан нэг жил) хугацааг хэлнэ.

Гэсэн хэдий ч мөрдөгч анхаарвал зохих хугацааг тогтоохын өмнө хууль тогтоомжийн тусгай заалт, шүүхийн тайлбарт тухайн улсын шүүх эрх мэдлийн хүрээнд анхаарвал зохих хугацааг хэрхэн тогтоохыг тодорхойлсон эсэх, мөн анхаарвал зохих хугацааг тогтсон хугацааны хооронд тогтоох шаардлагатай эсэхийг шалгах ёстой.

### **3.2.2 Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн ямар хөрөнгө чинээний төрлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд авч үздэг вэ?**

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийн төрөл болон ямар төрлийн “хөрөнгө чинээ”-ний тооцоололд үндэслэсэн болох нь мөрдөгчийн анхаарвал зохих хугацаанд нөлөөлж болно. Хэрэв, мөрдөн шалгах ажиллагаа нь харьцангуй өндөр өртөг бүхий амьдралын хэв маягтай эсхүл амьжиргааны түвшинтэй байгаа үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэрэгтэй холбоотой бол тухайн этгээдийн амьдралын хэв маяг, амьдралын түвшинг хадгалах талаар удаан хугацааны туршид хийсэн бүх зарцуулалтыг тусгахад илүү өргөн хүрээтэй анхаарвал зохих хугацаа шаардагдаж болно.

Гэхдээ, хэрэв мөрдөгч тухайн этгээд тодорхой хэмжээний нийцгүй эд хөрөнгө (жишээ нь, байшин) худалдан авч үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн болохыг тогтоохоор оролдож байгаа бол анхаарвал зохих хугацааны эцсийн өдөр нь уг этгээд тухайн хөрөнгийг олж авсан өдөр байх нь ойлгомжтой. Эсхүл, хэрэв тухайн хөрөнгө нь нэгжлэг хийх явцад олдсон их хэмжээний бэлэн мөнгө бол анхаарвал зохих хугацаа дуусах өдөр нь мөрдөгч бэлэн мөнгө илрүүлсэн өдөр байх болно.

### **3.2.3 Тухайн этгээд тодорхой хугацаанд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэдгийг илтгэх улаан туг буюу анхааруулсан шинж тэмдэг байдаг уу?**

Мөрдөгч анхаарвал зохих хугацааг тогтоохдоо өөрт байгаа нотлох баримтад дүн шинжилгээ хийж, тухайн этгээд хууль ёсны орлогоосоо илүү их хөрөнгө чинээг олж авсан, эсхүл илүү их мөнгөн хөрөнгө ашигласан хугацааг тодорхойлох шаардлагатай.

Мөрдөгчийн анхаарах ёстой хэд хэдэн улаан туг буюу шинж тэмдэг байдаг бөгөөд эдгээрт тухайн этгээд нь:

- Ерөнхийдөө нэмэгдсэн түвшний гүйлгээ хийж эхэлсэн;
- Их хэмжээний бэлэн мөнгө дансандаа хийх буюу данснаас гаргаж авах;
- Том хэмжээний худалдан авалт хийх;
- Ердийн бус их хэмжээний зээл авах;
- Хэвийн бус аялалд явах; эсхүл
- (Төрийн албан хаагчдын хувьд) авлигад өртөх боломжтой ажил үүрэг гүйцэтгэж эхэлсэн.

Эдгээр анхаарах шинж тэмдэг нь уг этгээд нь тухайн хугацаанд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн болохыг илтгэж болзошгүй тул мөрдөгчид эдгээр цаг хугацаанд дүн шинжилгээ хийх ёстой.

### **3.2.4 Тухайн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг нарийн нягталж шалгасан/шалгаагүй үлдсэн цаг хугацаа байна уу?**

Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тодорхой цаг хугацааг нарийн тогтоох боломж нь орсон болон гарсан гүйлгээний талаар цуглуулсан нотлох баримтын нарийвчилсан дэлгэрэнгүй дүн шинжилгээнээс ихээхэн хамаардаг.

Хэрэв мөрдөгч тухайн этгээдтэй холбоотой орсон болон гарсан гүйлгээ тус бүрийн огноо, цагийг тодорхой заасан нотлох баримтыг цуглуулж чадсан бол техникийн хувьд тухайн этгээдийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хугацааг өдөр өдрөөр нь нарийвчлан үнэн зөв тооцоолж гаргахын тулд түүний банкны болон мобайл дансны үлдэгдлийн нийлбэр дүнгийн хамт эдгээр гүйлгээ тус бүрийг Microsoft Excel гэх мэт программд тоон матрицад оруулах боломжтой байх болно.

Гэхдээ, бодит байдалд, ялангуяа бэлэн мөнгөний гүйлгээ ихтэй орнуудад эсхүл тухайн этгээд хамтран ажиллахгүй байх тохиолдолд орлого, зарцуулалтын төрөл тус бүрийн нарийвчилсан тодорхой цаг хугацаа, огнооны талаар нотлох баримт цуглуулах боломжгүй байдаг. Ийм тохиолдолд, тодорхой үнэ цэнэ бүхий гүйлгээг тодорхой бус хугацаанд хийгдсэн гэдгийг нотлох боломжтой бөгөөд ингэснээр мөрдөгч илүү өргөн хугацаанд орсон болон гарсан гүйлгээг харьцуулж, анхаарвал зохих хугацааг тодорхойлох боломжтой болох юм.

### **3.2.5 Тухайн этгээд сүүлд мөрийг нь олох боломжгүй болсон их хэмжээний бэлэн мөнгө гаргаж авсан уу?**

Мөн адилаар, хэрэв тухайн этгээд банкны данснаасаа их хэмжээний бэлэн мөнгө гаргаж авах буюу зарлагдах тохиолдол байдаг бөгөөд түүнийг дараа нь хэрхэн ашигласан болохыг нь нотлох арга байхгүй бол эдгээр цаг хугацааны үе нь эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээний оновчтой байдлыг гажуудуулах болно. Учир нь, Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээнд бэлэн мөнгө зарлагдахыг бус харин зөвхөн бодит нотлох боломжтой зардлыг тооцоолох боломжтой байдаг. Иймд, хэрэв мөрдөгч тухайн этгээд данснаасаа авсан бэлэн мөнгөөр юу хийснийг нотолж чадахгүй бол уг хөрөнгийг үндсэндээ алга болсонд тооцож, зарцуулалтад тооцох боломжгүй болно. Тиймээс, энэ жишээн дээр хэрэв боломжтой бол мөнгөн

хөрөнгө нь тухайн этгээдийн мэдэлд байсан (жишээ нь, банкны үлдэгдэл дээр харагдах) үед, тухайн этгээдийн банкны эцсийн үлдэгдэлтэй холбоотой нийт зарцуулалтад тусгахаар анхаарвал зохих хугацаа дуусах үеийг тогтоох нь дээр байдаг.

Тухайлбал, хэрэв Ноён Жон Дое (өмнө нь хадгаламжгүй байсан) жилийн хугацаанд:

- 1 дүгээр сараас 12 дугаар сарыг хүртэл 12 сарын хугацаанд сард 5,000 ам.доллар (нийт 60,000 ам.доллар) олсон; гэхдээ
- Уг 12 сарын хугацаанд 70,000 ам.доллар зарцуулсан; ба
- банкны дансандаа 30,000 ам.долларын үлдэгдэл хуримтлуулсан...

...энэ тохиолдолд энэ бүх үеийг хамарсан Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээгээр Ноён Дое нь үндэслэлгүйгээр 40,000 ам.доллороор хөрөнгөжсөн болохыг харуулах болно:

**[70,000 зарлага + 30,000 банкны эцсийн үлдэгдэл] хасах нь [60,000 орлого] тэнцүү [40,000 үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн] болно.**

Жич, хэрэв Ноён Дое 11, 12 дугаар сард банкны данснаасаа үлдэгдэл бүх мөнгөө татсан бөгөөд энэ мөнгөөр юу хийснийг нь нотлох боломжгүй байсан бол уг Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ нь огт өөр (алдаатай) үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн дүнг харуулах болно.

**[70,000 зарлага + 0 банкны эцсийн үлдэгдэл] хасах нь [60,000 орлого] тэнцүү [10,000 үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн] болно. Хэдийгээр, Ноён Дое 10 дугаар сард ихээхэн хэмжээний мөнгө хуримтлуулсан нь мэдэгдэж байсан ч, Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээг бүтэн жилийн хугацаанд анхаарвал зохих хугацаагаар тооцож хийсэн бол үр дүнд нь гарсан тоо нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн дүнг бүрэн хэмжээгээр үнэн зөвөөр тусгадаггүй байна.**

Иймд, анхаарвал зохих хугацааг сонгохдоо мөрдөгч эдгээр хөрөнгийг дараа нь хэрхэн ашигласан болохыг нотолж чадахаас бусад тохиолдолд боломжтой бол их хэмжээний бэлэн мөнгө авсан хугацааг оруулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Тухайлбал, дээрх Ноён Дое-гийн хялбаршуулсан жишээн дээр анхаарвал зохих хугацааг бүтэн жилээр бус зөвхөн 1 дүгээр сараас 10 дугаар сар хүртэлх хугацаагаар тогтоох нь илүү оновчтой байх болно.

Урт удаан хугацааны туршид илрүүлэх боломжгүй их хэмжээний бэлэн мөнгө зарлагадсан тохиолдолд Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийхгүйгээр нотлох стратегийг ашиглах нь зүйтэй юм.



### 3.2.6 Тодорхой хугацаа хүртэл хадгалуулсан хөрөнгийг үнэн зөвөөр тогтоох боломжтой юу?

Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэрэгт буруутгагдаж буй шүүгдэгчийн гаргадаг нийтлэг үндэслэл нь прокурорын нотлох баримтууд нь тухайн этгээдийг шалгаж буй анхаарвал зохих хугацаанаас өмнө олсон орлогыг тооцоогүй гэж үздэг явдал юм. Тухайлбал, прокурорын нотлох баримт нь тухайн этгээдийн төрийн албанд байсан үеийг бүхэлд нь хамарч байгаа тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэсэн төрийн албан тушаалтны зүгээс прокурорын нотлох баримтууд нь алдаатай бөгөөд тухайн этгээдийн төрийн албан хаагч болохоос өмнө авч байсан цалин орлогыг тооцохгүй байна гэж маргадаг.

Иймд, анхаарвал зохих хугацааг сонгохдоо тухайн этгээдийн эзэмшиж буй нийт хадгаламжийг нотлох баримтаар тогтоогдсон тодорхой өдрөөр анхаарвал зохих хугацааг эхлүүлэх нь зүйтэй. Тухайлбал, тухайн этгээд аливаа нэг нотлох боломжтой хадгаламж хуримтлуулж амжаагүй байх үе, эсхүл тухайн этгээдийн нийт хадгаламж цахим хэлбэрээр (жишээлбэл, банкны үлдэгдэл дээр) тодорхой харагдаж байх үе нь хамгийн оновчтой хугацаа байх болно.



Эх үүсвэр ба зарцуулалтын дүн шинжилгээ хийх талаар дэлгэрэнгүй мэдээллийг Базелийн засаглалын хүрээлэнгийн LEARN мэдээллийн сан болон “Эх үүсвэр зарцуулалт (Source and Application)” гарчигтай онлайн сургалтаас үзнэ үү. [learn.baselgovernance.org](http://learn.baselgovernance.org)





Эндрью Дорнбьерерийн Үндэслэлгүйгээр хөрөнгөжих асуудлын тухай ном нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомж, тэдгээрийг тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ болон авлига ба бусад гэмт хэргийн гаралтай орлогыг буцаахад зориулан хэрхэн хэрэглэх талаар тусгасан дэлгэрэнгүй гарын авлага юм. Энэхүү бүтээлд, дэлхийн улс орнуудад хэрэглэж байгаа үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай иргэний болон эрүүгийн хуулийг аль алийг авч үзсэн.

Үндэслэлгүйгээр их хэмжээгээр нэмэгдсэн хөрөнгө чинээтэй холбоотой хэрэглэж болохуйц эрх зүйн олон төрлийн арга хэрэгслийн практик хэрэглээ, хэргээ шүүхээр хэрхэн хянан шийдвэрлүүлэх болон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай холбоотой үүсэх түгээмэл сорилтуудыг дэлгэрэнгүй тусгаснаар энэхүү ном нь мөрдөгч, прокурор, хууль тогтоогчид, судлаач нарт хэрэгцээтэй ном болжээ.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих асуудлын тухай номыг Базелийн Засаглалын Хүрээлэнгийн Хөрөнгө буцаах олон улсын төвийн дэмжлэгтэйгээр боловсруулан хэвлүүлсэн бөгөөд судалгаа шинжилгээний ажилд Нью-Йоркийн Их сургуулийн Хууль зүйн сургууль хамтран ажилласан болно.

ISBN 978-3-9525409-4-7



9 783952 540947

INTERNATIONAL CENTRE FOR  
ASSET RECOVERY